



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

БИЕЙН ТАМИР

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

БИЕЙН ТАМИР

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|----------------------------|---|
| Суралцагчийн үнэлгээ | 2 |
|----------------------------|---|

БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

| | |
|---|----|
| Нэг. Хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж | 5 |
| 1.1. Үнэлгээний шалгуур боловсруулсан үндэслэл | 5 |
| 1.2. Үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдал..... | 10 |
| 1.3. Биеийн тамирын хичээлийн үнэлгээний аргын онцлог | 14 |
| Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар | 17 |
| 2.1. Бага боловсролын түвшний даалгаврын жишээ аргачлал | 17 |
| 2.2. Суурь боловсролын түвшний даалгаврын жишээ аргачлал..... | 24 |
| 2.3. Бүрэн дунд боловсролын түвшний даалгаврын жишээ аргачлал | 31 |
| Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал..... | 37 |
| 3.1. Суралцахуйн үр дүнд хүрснийг харуулах баримт нотолгоо цуглуулах, түүнийг шинжлэх | 37 |
| 3.2. Нэгжийн төлөвлөлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах | 46 |
| Ашигласан ном, материал | 49 |

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

1.1. Үнэлгээний шалгуур боловсруулсан үндэслэл

Үнэлгээ гэдэг нь сурган хүмүүжүүлэх үйл явц болон суралцах үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж ямар үр дүнд хүрснийг мэдэж авахын тулд тодорхой зорилго бүхий үйл ажиллагаа зохион байгуулж мэдээлэл цуглуулах үйл явц юм.

Сургалтын үйл ажиллагаанд оношлох, явцын, үр дүн (эцсийн)-гийн буюу амжилтын гэсэн үндсэн 3 төрлийн үнэлгээ түгээмэл ашигладаг.

1. Оношлох үнэлгээ: (diagnostic assessment). Оношлох үнэлгээ гэдэг нь хичээлийн жилийн эхэнд эсвэл сургалтын үйл ажиллагаа (нэгж хичээл, бүлэг сэдэв) эхлэхээс өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тандах зорилгоор хийх үнэлгээ юм. Өөрөөр хэлбэл, суралцагчийн сурах үйл ажиллагаанд гарч байгаа бэрхшээл, түүний шалтгааныг илрүүлэхэд тусална гэсэн үг. Оношлох үнэлгээ нь суралцагчийн давуу, сул талыг илрүүлэх, тэдний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн хичээл, сургалтын үйл ажиллагааг бүтээлч, үр дүнтэй зохион байгуулах төлөвлөлт хийхэд багшид дэмжлэг болдог. Биеийн тамирын хичээлээр оношлох үнэлгээ хийх хэд хэдэн түгээмэл хэлбэр байдаг.

1. Бие бялдрын бэлтгэлжилтийн сорил
2. Бие бялдрын хөгжлийн судалгаа
3. Ярилцлага
4. Асуулт, хариулт

Оношлох үнэлгээ хийх схем



2. Явцын үнэлгээ (Formative assessment). Суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын үйл явцад тогтмол хийх үнэлгээг явцын үнэлгээ гэж ойлгоно. Энгийнээр “явцын үнэлгээ” гэж сурах, сургах үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэдэг мэдээлэл гэж үздэг.

| Үнэлгээ | Юуг үнэлэх вэ? | Яаж үнэлэх вэ? |
|---------------|-------------------------------------|---|
| Явцын үнэлгээ | Сурагчийн ахиц дэвшил | Танин мэдэхүйн ба хөдөлгөөний чадварын түвшинд тохирсон даалгавар боловсруулж хянах |
| | Сурагчийн ташаа ойлголт | Ажиглалт, дасгалын гүйцэтгэлээр илрүүлж залруулах |
| | Сурагчийн хоцрогдож байгаа шалтгаан | Хоцрогдож буй шалтгааныг ажиглалт, даалгавраар тодруулах |
| | Сурагчийн амжилт | Урамшуулах |


Явцын үнэлгээ дараах ач холбогдолтой:

1. Тухайн сэдэв, бүлэг сэдвийн суралцахуйн зорилтыг суралцагчдад урьдчилан ойлгуулж, таниулах,
2. Суралцагчийн ахиц, дэвшлийг хянах, урамшуулах, өөртөө итгэх итгэлийг дэмжих,
3. Суралцагч бие даан эсвэл багшийн тусламжтай юу хийж чадах вэ? гэдгийг тодорхойлоход багш, суралцагчдад дэмжлэг үзүүлэх,
4. Суралцагч хэрхэн сайн суралцах, амжилтаа ахиулахын тулд цаашид ямар зүйлд анхаарах шаардлагатай вэ? гэдгийг мэдэхэд дэмжлэг үзүүлэх,
5. Суралцагчийн ялгаатай түвшин, гүйцэтгэлийг харгалзан тэдгээрт тохиорсон арга зүй сонгоход багшид дэмжлэг үзүүлэх,

Биеийн тамирын хичээлийн явцын үнэлгээнд дараах аргуудыг ашиглана.

1. Ажиглаж үнэлэх арга
2. Сургалтын нормоор үнэлэх арга
3. Хөдөлгөөний тестээр үнэлэх арга
4. Ярилцлагын арга
5. Сургалтын тэмцээнээр үнэлэх арга
6. Аман үнэлгээний арга
7. Бичгийн тест
8. Рубрик
9. Өөрийн болон найз нөхдийн үнэлгээ

Явцын үнэлгээ хийх схем



Тодруулга: Явцын үнэлгээ нь суралцагчдыг үр дүнгийн буюу амжилт (эцсийн)-ын үнэлгээнд амжилттай шалгуулахад хөтлөх бөгөөд “Суралцагчид хэр сайн сурч байна? гэсэн асуултад өгөхөд чиглэнэ.

Явцын үнэлгээнд түгээмэл ашигладаг үр дүнтэй хэрэгслүүдийн нэг нь рубрик юм. Рубрик нь суралцагчдын гүйцэтгэлийн ялгаатай түвшнийг илрүүлэхэд ашигладаг багц шалгуур үзүүлэлт юм.


3. Үр дүн (эцсийн)-ийн буюу амжилтын үнэлгээ (summative assessment). Тодорхой хугацаанд (бүлэг сэдэв, улирал, хичээлийн жилийн төгсгөлд) суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, ойлголтыг хэмжих зорилгоор хийх үнэлгээг үр дүн (цаашид “эцсийн үнэлгээ” гэх)-ийн буюу амжилтын үнэлгээ гэнэ.

Эцсийн үнэлгээ нь дараах хэлбэртэй байж болно.

1. Бүлэг сэдвийн төгсөлд авах шалгалт
2. Явцын үнэлгээний дундажийг тооцох
3. Стандартын хөдөлгөөний тест
4. Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн судалгаа

| Үнэлгээ | Юуг үнэлэх вэ? | Яаж үнэлэх вэ? |
|----------------|------------------------------------|---|
| Эцсийн үнэлгээ | Мэдлэг, чадвар, дасгалын гүйцэтгэл | <ul style="list-style-type: none"> • Ажиглаж үнэлэх арга • Сургалтын нормоор үнэлэх арга • Хөдөлгөөний тестээр үнэлэх арга • Сургалтын тэмцээнээр үнэлэх арга гэсэн эдгээр аргуудаас ашиглан үнэлэх |

Эцсийн үнэлгээ хийх схем



Тодруулга: Үр дүн (эцсийн)-ийн буюу амжилтын үнэлгээ нь суралцагчийн амжилттай холбоотой дүгнэлт, шийдвэр гаргахад чиглэх бөгөөд “Суралцагчид хэр зэрэг сайн сурсан бэ? гэдэг асуултад хариулт өгнө.

Үнэлгээг хэрхэн хийж байгаагаас нь хамаарч:

- Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ - биеийн тамирын дасгал, даалгавар, үйлийн гүйцэтгэх чадварын түвшнийг үнэлнэ.
- Шалгуурт суурилсан үнэлгээ - хүрэх үр дүнг хангасан байдлыг жил, агуулгын хүрээ, суралцахуйн зорилт, нэгж, ээлжит хичээлээр үнэлнэ.
- Нормчилсон үнэлгээ - сурлагын амжилтаар харьцуулах зорилгоор сургалтын норм боловсруулж үнэлнэ.

Суралцагчийг үнэлэхийн тулд:

- Суралцахуйн ерөнхий зорилго, зорилт дэвшүүлнэ.
- Оношлох үнэлгээ хийнэ.
- Оношлох үнэлгээний үр дүнгээс суралцахуйн тодорхой зорилтыг дэвшүүлнэ.
- Суралцахуйн зорилтыг хангах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна.
- Сурагчдын суралцахуйг дэмжсэн сургалт явуулна.
- Явцын болон үр дүнгийн үнэлгээ хийнэ.

Эндээс үзвэл үнэлгээ бол суралцахуй болон багшлахуйг сайжруулах хэрэгсэл болох нь харагдаж байна.

Үнэлгээний даалгавар гэж юу вэ? Сургалтын үр дүнг илрүүлэн сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшсөн хандлагыг үнэлэхийн тулд сурагчаар гүйцэтгүүлэх үйл юм.

Биеийн тамирын хичээлийн онцлогт нийцүүлэн:

- Мэдлэгийн үнэлгээний даалгавар
- Хөдөлгөөний чадварыг үнэлэх даалгавар
- Бие бялдрын бэлтгэлжилтийг үнэлэх даалгавар
- Эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа хөгжүүлэх арга барил эзэмшилтийг үнэлэх даалгавруудыг боловсруулж үнэлгээнд ашиглана.

Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур боловсруулах эрх зүйн үндэслэл юу вэ?

Сургалтын байгууллагын үнэлгээ¹, сурагчдын сурлагын амжилтын үнэлгээ² болон багшийн ажлын үнэлгээ³-тэй холбогдох эрх зүйн зохицуулалтын ерөнхий төлөв байдлыг тодорхойлох агуулга бүхий захиалгат ажил⁴-ын хүрээнд хийсэн судалгааны ажлаас “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам” баталсан.

Монгол улсын нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөн 1990-ээд оноос эхэлсэн боловсролын салбар дахь өөрчлөлт шинэчлэл нь нийгмийн шинэ харилцаанд нийцүүлэн бүхэл бүтэн тогтолцооны шинэчлэл байсан бөгөөд өнөөдөр ч энэ үйл явц гүнзгийрсээр байна. Тухайлбал, бага дунд боловсролын үндэсний стандарт, сургалтын хөтөлбөрүүд, сурах бичгийн хангамж, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийг харилцан уялдаатай хөгжлийн бодлого, стратегийг бодит үйл хэрэг болгон хувиргах талбар нь цэцэрлэг, ЕБС-иуд байсан.

ЕБС-ийн сурагчийн мэдлэг, чадварыг үнэлэх, анги дэвших болон улсын шалгалтыг зохион байгуулахтай холбоотой 40 гаруй эрх зүйн баримт бичиг 1929 оноос хойш гарсан байна. Үүнээс 1936-2018 оны хооронд гарсан ЕБС-ийн сургалтад мөрдөгдөж байсан болон одоо мөрдөгдөж буй үнэлгээний 7 журамд хийсэн бодлогын түүхчилсэн судалгаа⁵-наас Монгол улсад хэрэгжүүлсэн суралцагчийн үнэлгээний бодлогын хөгжлийн “шинэ үе” буюу 4-р үеийг эхлүүлж байна гэж

¹ БСШУС-ын Сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”

² БСШУС-ын Сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар баталсан “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”

³ “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ын төсөл

⁴ “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл” L3594-MON-ийн санхүүжилтээр БШУЯ болон судлаачдын багийн хооронд байгуулсан БШУ/29 ба БШУ/27 тоот гэрээ, түүний хавсралтын дагуу гүйцэтгэв.

⁵ Түмэнбаяр, Д., Нямгэрэл, Ч., Батчимэг, Ө., Амартайван, Ц. ба Мягмар, П. (2019). “ЕБС-ийн суралцагчийн мэдлэг чадварын үнэлгээний талаарх зарим бодлогын түүхчилсэн судалгаа”. УБ.Боловсрол судлал.х.х.4-22.

дүгнэсэн. Энэ нь үнэлгээнд баримтлах зарчим, үнэлгээний зорилго, үнэлгээний хэлбэр, үнэлгээний арга, эргэх холбоо, дүн шинжилгээ зэрэгтэй холбоотой заалтуудад хийгдсэн өөрчлөлттэй холбоотой байна. Эдгээрээс хамгийн том эргэлтийн шинжтэй бодлогын өөрчлөлт нь “шалгуурт суурилсан үнэлгээний тогтолцоо”-г хэрэгжүүлэх бодлогын шийдэл юм.⁶

БСШУС-ын Сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар баталсан. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээ нь шалгуурт суурилсан байх бөгөөд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, Боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж батална” гэж заасан байна.

Үнэлгээний шалгуур боловсруулахдаа дараах зарчмуудыг баримталсан. Үүнд:

- Суралцагчийн үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөнөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзлэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх,
- Үнэлгээний даалгавар нь суралцагчийн бие бялдрын хөгжил, хөдөлгөөний чадварын ялгаатай байдалд тохирсон байх.
- Үнэлгээний шалгуур нь анги тус бүрийн биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт, суралцахуйн үр дүнд баримжаалсан байх
- Үнэлгээний шалгуур нь хөдөлгөөний үйлдэлтэй танилцах, хөдөлгөөний үйлдлийг эзэмших, хөдөлгөөний үйлдлийг төгөлдөржүүлж дадал болгох шатны онцлогт нийцсэн байх зэрэг болно.

Түүнчлэн боловсролын зорилгын таксономи болох Б.Блумын таксономи, үйл ажиллагааны явцад сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх конструктив хандлагыг ашиглана.

Үнэлгээний шалгуур (критерия-criteria): Тодорхой зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин (UNESCO-CEPES 2007)-г үнэлгээний шалгуур гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл, суралцахуйн үр дүнг хангаж буй байдалд тавигдах шаардлага юм.

Үнэлгээний шалгуур боловсруулахын ач холбогдол юу вэ?

- Суралцагчдад юу мэдэх, чадах хэрэгтэйг тодруулж өгөх,
- Суралцагчид суралцахуйн чухал, үнэ цэнэтэй үр дүнд нь анхаарлаа хандуулах,
- Суралцагчид суралцахуйн үр дүнгийн өөр түвшинд хүрэхийн тулд юу хийх хэрэгтэйг ойлгох чадвартай болох,
- Багшлахуй, суралцахуйн зорилтыг нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх болно. Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг дараах алхмаар боловсруулсан.

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг задлан шинжлэх + үнэлгээний нэгжийг төлөвлөх + нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлох + үнэлэх шалгуур боловсруулах + гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт боловсруулах

Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудыг задлан шинжилж хичээлийн жилийн хүрээнд суралцахуйн хүрэх үр дүнг тодорхойлсноор үнэлгээний нэгжийг тогтоосон. Эндээс тухайн үнэлгээний нэгжид тохирох суралцахуйн үр дүнг боловсруулж, түүнийг хангах шалгууруудыг нарийвчлан, гүйцэтгэлийн дөрвөн түвшинд тодоройлсон болно.

Биеийн тамирын хичээлийн үнэлгээний зорилго нь нэг талаасаа хичээл дээр өгөгдсөн ачаалал, дасгалууд, багшийн хэрэглэсэн арга барил нь суралцагчдын хөгжилд хэр нөлөө үзүүлснийг илрүүлнэ. Нөгөө талаас суралцагчдын мэдлэг, эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, хөдөлгөөний чадварт ямар ахиц өөрчлөлт гарсныг үнэлэхэд оршино.

Боловсролын түвшин бүрт хүүхдийн нас, бие бялдрын хөгжил, хөдөлгөөний эв дүй, сэтгэхүйн онцлогт тохируулан үнэлгээ хийнэ.

⁶ Нямгэрэл,Ч., Нэргүй,Н. (2021). “Суралцагчийн Үнэлгээний журамд хийсэн эрх зүйн шинжилгээний үр дүн”.УБ: Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам 2021 эрдэм шинжилгээний хурал -VII. х.133.

1.2. Үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдал

Биеийн тамирын хичээлийн хувьд нэгж, СҮД, үнэлгээний шалгуур болон гүйцэтгэлийн дөрвөн түвшнийг боловсруулахдаа сайжруулсан хөтөлбөрийн зорилго, зорилт, сурагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг баримталсан. Тодруулбал,

- Бие бялдрын түвшин тогтоох сорилын шалгуураар өөрийн түвшингээ тодорхойлох, үнэлэх, хянах,
- Судалж буй спортын төрлийн техник, тактикийг зөв гүйцэтгэх, ур чадвараа дээшлүүлэх,
- Судалж буй спортын төрлийн техник, тактикийг тоглолт, тэмцээнд хэрэглэх,
- Өөрийн бие бялдраа хөгжүүлж, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, эмчилгээний биеийн тамирын дасгалыг зохих зааврын дагуу ашиглах, эрүүл мэндээ хамгаалж чаддаг байх зэрэг болно.

А. Үнэлгээний нэгж (unit assessment)-ийг тодорхойлсон байдал

- Анги тус бүрийн биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн агуулгын бүлэг сэдэвт нийцүүлэн суралцахуйн зорилтуудыг нэгтгэж үнэлгээний нэгж болгосон.
- Нэгжийн агуулгыг судалсны дараа сурагч найдвартайгаар харуулж чаддаг болсон байх хамгийн чухал, ач холбогдолтой суралцахуйн үр дүнг тооцсон.
- Аль болох ерөнхийлсөн олон талт мэдлэг, чадварыг харуулсан байхаар суралцахуйн үр дүнг томъёолсон.
- Нэгжийн хүрээнд цөөн тооны суралцахуйн үр дүнг томъёолсон.

Бага боловсролын I-V ангийн үнэлгээний нэг нэгжид хэд хэдэн суралцахуйн үр дүнг тодорхойлсон. Үүнд,

- Ахуйн хэрэгцээт дасгал
- Алхах, гүйх
- Үсрэх, харайх
- Шидэх, дамжуулах гэсэн дөрвөн бүлэг сэдвийн нэрээр нь үнэлгээний нэгж болгосон.

Суурь боловсролын VI-IX ангид:

- Бие бялдрын хөгжил
- Гимнастик (Арэобик, Бүжиг)
- Хөнгөн атлетик
- Сагсан бөмбөг
- Хөл бөмбөг
- Волейбол
- Үндэсний спорт-(Хурдан морины уралдаан, Сур харваа, Бөхийн барилдаан, Шагайн харваа) гэсэн долоон бүлэг сэдвийн нэрээр нь үнэлгээний нэгж болгосон.

Бүрэн дунд боловсролын X-XII ангид:

- Бие бялдрын хөгжил
- Олон улсын спортын хөгжил
- Хөнгөн атлетик
- Сагсан бөмбөг
- Волейбол
- Хөл бөмбөг
- Аэробик гэсэн долоон бүлэг сэдвийн нэрээр нь үнэлгээний нэгж болгож авсан.

Үнэлгээний нэгж тус бүрээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүнг боловсруулсан.

Суралцахуйн зорилтоос үнэлгээний нэгжийг тодорхойлсон жишээ

Үнэлгээний нэгж: (unit assessment) САГСАН БӨМБӨГ

| № | Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр | Нэгж /unit assessment/ |
|---|--|------------------------|
| 1 | 10.4а. Хуурмаг хөдөлгөөнийг зогсолт, алхалт, гүйлт, залалттай хослуулан шилжилт, эргэлт хийж гүйцэтгэх 10.4б. Залалт ба дамжуулалтаас шулуун, хөөргөж, шаланд ойлгон оновчтой дамжуулж, зогсолт хийн үсэрч шидэх, хоёр алхамтаас шидэлтийг гүйцэтгэх 10.4в. Чигээрээ ба чиглэлээ өөрчлөн гүйж буй довтлогчийг хамгаалах, ашигтай байрлал эзэлсэн бөмбөггүй тоглогчийг хамгаалах, 2х2, 3х3-аар хувийн хамгаалалтыг гүйцэтгэх 10.4г. Сагсан бөмбөг тоглохдоо шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлэх | Сагсан бөмбөг |

Б. Суралцахуйн үр дүнг томъёолсон байдал

Суралцахуйн үр дүн: Тухайн хичээлийг амжилттай дуусгахад, хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай суралцахуйн амжилтыг тодорхойлох тусгай илэрхийлэл юм.

Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хичээлийг судалж дууссаны дараа харуулж чаддаг болох ёстой тусгай төрх байдал (behaviours)-ыг тодорхойлдог.

Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрөөр суралцаж дүүргэсний дараа сурагчийн хүлээсэн мэдлэг, чадвар, үнэт зүйл хандлагад чиглэсэн байх ёстой.

Суралцахуйн үр дүнд:

- Өргөн хүрээний концепцийн мэдлэг, тусгай болон ерөнхий чадварыг тусгадаг.
- Хамгийн чухал мэдлэг, чадвар, хандлагыг тусгадаг.
- Суралцахуйн туршлагын үр дүнд анхаарал хандуулах боломжийг өгдөг.
- Суралцахуйн туршлагын хүссэн үр дүнг тусгахаас биш үйл явцыг авч үзэхгүй.
- Хөтөлбөрийг амжилттай дуусгахад олж авсан байх ёстой минимум гүйцэтгэлийг авч үздэг.

Нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон жишээ

Үнэлгээний нэгж (unit assessment) САГСАН БӨМБӨГ

| № | Нэгж /unit assessment/ | Суралцахуйн үр дүн |
|---|------------------------|---|
| 2 | Сагсан бөмбөг | Сурагч сагсан бөмбөг тоглохдоо үндсэн техникүүдийг ашиглан, шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлнэ. |

Суралцахуйн үр дүнг боловсруулахдаа "ABCD" аргыг баримталсан болно. Энэхүү аргаар суралцахуйн үр дүнг дараах шаардлагыг баримталж боловсруулсан. Үүнд,

| | | | |
|---|--|-----------|---|
| A | Сонсогч /Audience | Хэн | СҮД хэнд хандсан бэ? |
| B | Төрх байдал (Behaviour) буюу гүйцэтгэл | Юу | Сурагчид юуг мэддэг, чаддаг болно гэж хүлээж байна вэ? Идэвхтэй үйл үгээр илэрхийлнэ. |
| C | Нөхцөл (Condition) | Хэрхэн | Ямар нөхцөл байдал, хязгаарлалтад сургалтыг явуулах вэ? |
| D | Degree | Хэр зэрэг | Төрх байдлыг хэр зэрэг (хэр сайн) ямар түвшинд гүйцэтгэсэн байх вэ? |

Биеийн тамирын суралцахуйн үр дүнг томъёолохдоо хичээлээр эзэмших чадварт суурилж агуулгыг багцалсан. Жишээ нь: Сурагч **хурдтай шилжиж, янз бүрийн чиглэлээс ирсэн бөмбөгийг зөв хүлээн авч оновчтой дамжуулалтыг гүйцэтгэдэг болно.**

Суралцахуйн үр дүнг нэгжийн агуулгыг судалсны дараа сурагч найдвартайгаар харуулж чаддаг болсон байх хамгийн чухал, ач холбогдолтой суралцахуйг тооцож, SMART байхаар томъёолсон болно.

Суралцахуйн үр дүнг гүйцэтгэлийн төлөв байдлаар нь нэгтгэх замаар өөрөөр хэлбэл, суралцагчийн эзэмшсэн мэдлэг ойлголт, хөдөлгөөний чадвар, бие бялдрын бэлтгэлжилт, чийрэгжилтийг үнэлэх, гүйцэтгэлд суурилсан чадваруудыг нэгтгэж үр дүн болгосон.

Суралцахуйн зорилт болон суралцахуйн үр дүнгийн ялгааг авч үзвэл:

| Суралцахуйн зорилт | Суралцахуйн үр дүн |
|-------------------------------------|---|
| Суралц | Суралц |
| Оролт | Гаралт |
| Чиглэсэн | Бодитой |
| Зорилтын илэрхийлэл | Гүйцэтгэлийн түвшний нотолгоо |
| Мэдлэг, чадварын тус тусдаа хэсгүүд | Өргөн хүрээний мэдлэг, чадвар |
| Хөтөлбөр, удирдамжид тулгуурласан | Хэрэглэх, өндөр түвшний суралцахуйд тулгуурласан |
| Жишээ | |
| Агуулга /мэдлэг | Сурагч дасгалыг зөв гүйцэтгэх ойлголт, төсөөлөлтэй болно. |
| Чадвар | Сурагч биеийн тамирын дасгалыг техникийн дагуу зөв гүйцэтгэдэг болно. |
| Хандлага | Сурагч дасгалаар хичээллэх хүсэл сонирхолтой болно. |

В. Үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулсан байдал

Суралцахуйн үр дүнг хангах шалгуурыг тухайн суралцахуйн үр дүнгийн томъёоллыг харгалзан хэд хэдэн үзүүлэлтээр боловсруулсан.

Суралцахуйн үр дүнгээс үнэлгээний шалгуурыг тодорхойлсон жишээ

Үнэлгээний нэгж (unit assessment) САГСАН БӨМБӨГ

| № | Суралцахуйн үр дүн | Суралцахуйн үр дүнгийн шалгуур |
|---|---|---|
| 3 | Сурагч сагсан бөмбөг тоглохдоо үндсэн техникүүдийг ашиглан, шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлнэ. | Хуурмаг хөдөлгөөний аргуудыг зөв сонгож гүйцэтгэдэг. |
| | | Сагсан бөмбөгийн залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулан үр дүнтэй гүйцэтгэдэг |
| | | Сагсан бөмбөг тоглохдоо довтолгоо, хамгаалалтын энгийн тактикийг ашигладаг. |
| | | Сагсан бөмбөг тоглохдоо дүрмийн мэдлэгээ ашиглан, шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлдэг. |

Г. Гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлсон байдал

Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг гүйцэтгэлийн дөрвөн түвшнээр нарийвчлан боловсруулсан.

Суралцахуйн үр дүнгийн шалгуураас гүйцэтгэлийн хүрэх түвшнийг тодорхойлсон жишээ

Үнэлгээний нэгж (unit assessment) САГСАН БӨМБӨГ

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН | | | |
|--|---|--|--|--|
| | I | II | III | IV |
| Хуурмаг хөдөлгөөний аргуудыг зөв сонгож гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний нэг арга мэддэг боловч түүнийгээ алдаатай гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний нэг аргыг зөв гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний аргуудаас заримыг нь зөв гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний аргуудыг бүгдийг зөв гүйцэтгэдэг. |
| Сагсан бөмбөгийн залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулан үр дүнтэй гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулахдаа зогсолттой, оновчтой биш гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулахдаа дунд зэргийн хурдтай, заримдаа оновчтой гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулан, хурдтай, оновчтой гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь зөв хослуулан, маш оновчтой, өндөр хурдтай гүйцэтгэдэг. |
| Сагсан бөмбөг тоглохдоо довтолгоо, хамгаалалтын энгийн тактикийг ашигладаг. | Бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан довтолох оролдлого хааяа хийдэг. Хувийн хамгаалалтаар довтологчийг хамгаалахыг оролддог. Бүлгийн хамгаалалтыг буруу, идэвхгүй гүйцэтгэдэг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан довтолгоо гүйцэтгэдэг. Хувийн хамгаалалтаар довтологчийг хамгаалахыг оролддог. Бүлгийн хамгаалалтад заримдаа байрлалаа буруу эзэлснээс алдаа гаргадаг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан үр дүнтэй довтолдог. Хувийн хамгаалалтаар довтологчийг хамгаалдаг. Бүлгийн хамгаалалтад байрлалаа зөв эзэлдэг боловч хамгаалахдаа алдаа гаргадаг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан үр дүнтэй довтолдог. Хувийн ба бүлгийн хамгаалалтын энгийн тактикийг оновчтой ашиглан довтологчийг хамгаалж чаддаг. |
| Сагсан бөмбөг тоглохдоо дүрмийн мэдлэгээ ашиглан, шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтыг багшийн ба нөхдийнхөө дэмжлэгтэй ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтын цөөнхийг ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтын ихэнхийг ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтыг бүгдийг ойлгодог, заалт бүрийг хэрэгжүүлдэг. |

1.3. Биеийн тамирын хичээлийн үнэлгээний аргын онцлог

Биеийн тамирын хичээлийн онцлогтой холбоотойгоор сурагчийн мэдлэг, ойлголтыг амаар, бичгээр үнэлэх бол хөдөлгөөний чадварыг дасгалын гүйцэтгэлийн шалгуураар үнэлнэ.

Биеийн тамирын хичээлийн үнэлгээнд дараах аргуудыг ашигладаг⁷.

А. Сурагчийн эзэмшсэн мэдлэгийг үнэлэх аргууд


Аман үнэлгээний арга. Сурагчийн эзэмшсэн мэдлэгийг үнэлэхдээ аман үнэлгээний хэлбэрийг ашиглана. Өөрөөр хэлбэл, сурагчийн ярьсан зүйлийн агуулга зөв эсэх, биеийн тамирын хэлээр ойлгомжтой ярьсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. Жишээ нь:

- Дээшээ үсрэхдээ гараа хэрхэн савах вэ? Яагаад? гэсэн асуултад хариулж ярих
- Тодорхой сэдвээр өөрийн ойлголтыг ярьж танилцуулах
- Тоглоомын болон тэмцээний дүрмийг тайлбарлах
- Биеийн тамирын дасгалаар хичээллэхийн ач холбогдлыг ярих
- Зураг дээрх хөдөлгөөний үйлдлүүдийг нэрлэж хэлэх
- Судалж буй сэдвийн хүрээнд нөхдөөсөө асуулт асуух гэх мэт хэлбэрүүд байж болно.

Бичгийн үнэлгээний арга. Биеийн тамирын хичээлээр сурагчдын эзэмшсэн мэдлэг, ойлголтыг бичгээр үнэлж болно. Ихэвчлэн хичээлийн бус цагаар, хугацаа тогтоож, тодорхой сэдэв, агуулгаар бичгийн ажил хийлгэх нь богино хугацаанд олон сурагчийг үнэлэх боломжийг хангана. Үүнд:

- Бичгийн тест буюу сорил гүйцэтгэх
- Спорт тоглоомын тактикийн зураглалыг тайлбарлан бичих
- “Чийрэгжүүлэх гүйлтээр хичээлэх товч зөвлөмж” бичих
- Асуултад хариулж бичих гэх мэт хэлбэр байж болно

Биеийн тамирын хичээлээр эзэмшсэн сурагчийн мэдлэгийг үнэлэхдээ бичгийн тест буюу сорилыг ашиглана. Энэ бичгийн сорилыг үнэлгээний даалгавар гэж ойлгоно. Үүний тулд бичгийн даалгаврын төрөл ямар байх вэ? гэдэгт анхаарлаа хандуулна.



Сонгох даалгавар: Шалгуулагч өгөгдсөн хариултын хувилбаруудаас хамгийн зөв хариултыг сонгох хэлбэрийн даалгаварыг хэлнэ. Сонгох даалгавар нь нэг ба олон сонголттой байхаас гадна харгалзуулах, гүйцээх, нөхөх хэлбэртэй байдаг.

Сонгох даалгавар нь хамгийн уян хатан магадгүй хамгийн үр дүнтэй зорилтот даалгаврын төрөл бөгөөд 2 хэсгээс бүрдэнэ.

- Үндсэн хэсэг буюу шалгуулагчид зориулсан асуулт, өгүүлэмж
- Тухайн асуултын хариулт байж болох боломжит хувилбарууд

Үндсэн хэсэг нь асуулт байдлаар эсвэл нөхөх хэсэг бүхий бүрэн гүйцэд бус өгүүлбэр хэлбэртэй байж болох ба өгөгдсөн хариултын хувилбаруудаас ганц нь зөв байдаг. Иймд олон сонголттой даалгаварыг сайн бичихийн тулд тодорхой хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй. Тухайлбал сонгох даалгавар нь сэргээн санах, ойлгох, мэдлэгээ бодит нөхцөлд хэрэглэх, дүн шинжилгээ хийх, үнэлэх, чадваруудыг сориход голлон анхаарч бичигдсэн байх хэрэгтэй, Олон сонголттой чадваруудыг сориход голлон анхаарч бичигдсэн байх хэрэгтэй⁸

Даалгавар боловсруулахад анхаарах зүйл:

1. Даалгавар гүйцэтгэхэд ач холбогдолгүй мэдээлэл оруулахгүй байх хэрэгтэй
2. Даалгаврын асуулт, өгүүлэмж нь зөв хариулттай холбоотой дохио, санаа агуулаагүй байх.
3. Даалгаврын хариултын сонголтууд дотор зөвхөн нэг л зөв хариулт байх ба хариултын бусад

⁷ Уртнасан, Л. (2017). "Биеийн тамирын хичээлийн үнэлгээний онцлог". УБ: БТСОА3.1(54).х. 25-26.

сонголтууд үнэмшилтэй байх боловч ямар ч тохиолдолд буруу байх.

4. Буруу хариултуудыг сайн боловсруулах нь олон сонголттой даалгавар боловсруулах ажлын хамгийн хэцүү хэсэг юм. Сорил боловсруулагч нь голдуу эхний 2 буруу хариултыг хялбархан боловсруулдаг боловч сүүлийн буруу хариултыг боловсруулахад амаргүй байдаг тул хялбар хариулт оруулах нь түгээмэл байдаг.
5. Даалгаврын хариултын сонголтууд логик дараалалтай байх
6. Даалгаврын хариултын сонголтууд давхцалгүй буюу бие биедээ агуулагдаагүй байх.
7. Даалгаврын хариултын сонголтуудын хэлбэр формат, дүрмийн бүтэц, хэмжээ (үг, үсгийн тоо, хэмжээ гэх мэт) ойролцоо байх.
8. Даалгаврын асуулт, хариултын сонголтуудад үгийг олон давтаж хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.
9. Хариултын хувилбаруудын тоо 3-аас багагүй, 5-аас ихгүй байх нь зохимжтой ба хувилбарууд анхаарал татахаар үнэмшилтэй байх хэрэгтэй.
10. Дээрх сонголтууд бүгд зөв, дээрх сонголтууд бүгд буруу гэсэн сонголтуудыг оруулахгүй байх хэрэгтэй.
11. Тестийн зөв хариултад харгалзах үсэг бүрийн эзлэх хувь хэмжээ ойролцоогоор тэнцүү байх хэрэгтэй⁸.

Задгай даалгавар: Суралцагч дэвшүүлсэн асуултад дэлгэрэнгүй байдлаар хариулахыг шаарддаг бөгөөд танин мэдэхүйн түвшний хувьд сэргээн санах, ойлгох ур чадвараас илүү дээд түвшний ур чадварыг үнэлэхэд чиглэгдэнэ.

Алхамтай задгай даалгаврын хувьд өмнөх асуултын хариултаа дараагийн асуултыг гүйцэтгэхэд ашиглаж болдог бол багц даалгаврын хувьд өмнөх асуултын хариултаа дараагийн асуултыг гүйцэтгэхэд ашигладаггүй байна. Задгай алхамтай даалгавар бага ангид 2-4 алхамтай, дунд ангид 2-6 алхамтай байж болно.

Даалгавар танин мэдэхүйн ямар түвшнийх байх вэ? АНУ-ын эрдэмтэн Блум хүний танин мэдэхүйг 6 түвшинд хуваан авч үзсэн.

а. Сэргээн санах түвшин, б. Ойлгох түвшин, в. Задлан шинжлэх түвшин, г. Хэрэглэх түвшин, д. Үнэлэх түвшин, е. Бүтээх түвшин гэсэн 6 түвшинд сурагчийг үнэлэхдээ танин мэдэхүйн түвшинд нь тохирсон даалгавар гүйцэтгүүлж үнэлнэ.

Б. Сурагчийн эзэмшсэн хөдөлгөөний чадварыг үнэлэх аргууд

Ажиглаж үнэлэх арга. Сурагч дасгалын техникийг хэрхэн гүйцэтгэж байгааг буюу хөдөлгөөний чадвар эзэмшилтийг үнэлэхэд энэ аргыг хэрэглэнэ. Сурагч дасгалыг зөв гүйцэтгэж байна уу?, алдаатай гүйцэтгэж байна уу? гэдгийг ажиглаж, багш хувийн журналдаа тэмдэглэл хөтөлнө. Дасгалын техникийн үндсэн хэсэгт алдаа гаргаж байвал том алдаанд тооцно, техникийн бүрдэл хэсэгт гарч буй алдааг жижиг алдаа гэж үзнэ. Дасгалын техник гүйцэтгэлийг үнэлэхдээ:

- Уг дасгалын техникийг бүрэн зөв, өөртөө итгэлтэй, чөлөөтэй гүйцэтгэвэл -дээд түвшин (дээд үнэлгээ)
- Дасгалын техникийг зөв, чөлөөтэй гүйцэтгэсэн боловч 1-2 жижиг алдаа гаргавал дундаж түвшин (дундаж үнэлгээ)
- Дасгалын техникийг чөлөөтэй гүйцэтгэсэн боловч техникийн үндсэн хэсэгт 1 алдаа гаргасан, эсвэл 3-аас дээш жижиг алдаа гаргавал -дундажаас доод түвшин (дундажаас доогуур үнэлгээ)
- Дасгалын техникт бүдүүлэг алдаа гаргасан, эсвэл 3-аас олон жижиг алдаа гаргавал доод түвшин (доод үнэлгээ) гэж үнэлнэ.

Хөдөлгөөний тестээр үнэлэх арга. Дасгалын техникийг агуулсан хяналтын тусгай дасгалаар сурагчдын техник гүйцэтгэлийг үнэлнэ. Үнэлгээний энэ тестийг суралцахуйн үр дүнгийн шалгуурт нийцүүлэн багш боловсруулна.

⁸ Ганбат, Л. бусад. (2019). "Даалгавар боловсруулах, даалгаврын сан ашиглах арга зүйн зөвлөмж". УБ.х.2-3.

В. Сурагчийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийг үнэлэх аргууд

Сургалтын нормоор үнэлэх арга. Биеийн тамирын хичээлээр судалсан дасгалыг гүйцэтгэх хөдөлгөөний чадвар ба бие бялдрын бэлтгэлжилтийг үнэлэх норм боловсруулж сурагчдыг үнэлнэ. Сургалтын нормыг тогтоохдоо заавал судалгаанд үндэслэх бөгөөд сурагчдын ялгаатай байдлыг харгалзан өөр өөр түвшинтэй норм боловсруулж болно. Суралцагчийн биелүүлж буй нормыг өмнөхтэй нь жишиж, ахиц амжилтыг тодорхойлно.

Хөдөлгөөний тестээр үнэлэх арга. Сурагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг хяналтын тусгай дасгалаар үнэлэх аргыг хөдөлгөөний тест гэдэг. Хөдөлгөөний тест нь тодорхой шалгуурыг хангасан байх шаардлагатай тул олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн “хөдөлгөөний тест”-ийг хичээлийн үнэлгээнд ашиглана.

Сургалтын тэмцээнээр үнэлэх арга. Тодорхой нэг бүлэг сэдвийн төгсгөлд тухайн спортын төрлийн тэмцээн зохион байгуулж, түүнд үзүүлсэн амжилтаар нь сурагчдыг үнэлэх аргыг биеийн тамирын сургалтад хэрэглэнэ. Энэ тэмцээн нь сурагчдын бие бялдрын бэлтгэлжилт болон дасгалын техник эзэмшилтийн талаар багшид нэлээд бодитой мэдээллийг өгдөг. Тэмцээнд оролцсон сурагчийн амжилт ахиагүй буюу өмнөх үзүүлэлтэйгээ адил байвал багш хичээлийнхээ агуулга, арга зүй, ачааллыг дахин анхаарч үзэх шаардлагатай болно.

Хэдийгээр нэг ангийн, ижил насны сурагчдын дунд тэмцээн зохион байгуулах боловч тэдний бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт, хөдөлгөөний чадварын ялгаатай байдлыг тооцон үзэж, тэд хамт өрсөлдөх нөхцлийг бүрдүүлсэн тохиолдолд л энэ арга үр дүнтэй хэрэгжинэ.

Эмнэлэгийн хяналтын энгийн аргаар үнэлэх. Биеийн тамирын хичээлээр сурагчдыг үнэлэхдээ биеийн жин, биеийн өндөр, уушигны амьдралын багтаамж, гарын ба нурууны хүчийг хэмжих зэрэг хүүхдийн бие бялдрын хөгжлийг хэмжих эмнэлэгийн хяналтын энгийн арга (антропометрийн)-ыг ашигладаг. Уг аргыг хэрэглэн хичээлийн жилийн эхэн, төгсгөлд заавал хүүхэд бүрийн бие бялдрын хөгжлийг оношлон тодорхойлох шаардлагатай.

Биеийн тамирын хичээлээр сурагчийг үнэлэх үйл ажиллагааг доорх дарааллаар явуулна.

1. Үнэлгээний төрлийг тогтооно. Өөрөөр хэлбэл: Түвшин тогтоох, оношлох, явцын, эцсийн үнэлгээний аль нь вэ? гэдийг тогтооно.
2. Үнэлгээний зорилтыг тодорхойлно. Тухайн сэдвийн агуулгын хамрах хүрээнээс шалтгаалан юуг (мэдлэг, чадварыг, бэлтгэлжилтийг) үнэлэхээ тодруулна.
3. Үнэлгээний зорилтыг хэрэгжүүлэх арга, хэлбэрийг сонгоно. Хөдөлгөөний тестээр, ажиглалтаар, нормоор, амаар, бичгээр, тэмцээн зэргээс сонгож, үнэлгээний даалгаврыг боловсруулан, ашиглах хэрэгслээ бэлтгэнэ.
4. Үнэлгээний шалгуурыг боловсруулна.
5. Даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал боловсруулна.
6. Сурагчдын мэдлэг, чадвар, бэлтгэлжилтийг үнэлж дүгнэх⁹.

Биеийн тамирын хичээлийн үнэлгээний үр дүнг сурагчид болон эцэг эхчүүдэд танилцуулж, хүүхдийн цаашдын хөгжилд чиглүүлж ажиллах хэрэгтэй.

Үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа:

- Хураангуй бюпринт хийх
- Дэлгэрэнгүй бюпринт хийх
- Даалгавар бүрийн дэлгэрэнгүй мэдээллийн матриц гаргана.

☑ *Зөвлөмжид санал болгосон даалгавруудыг ашиглахдаа тухайн сурагчийн даалгаврын гүйцэтгэлийн ялгаатай байдал, тухайлбал, суурь чадварын онцлог, мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшин, сурах арга барил, бие бялдрын хөгжлийн ялгаатай байдал зэргийг харгалзан сурагчдын хөгжлийг дэмжинэ.*

⁹ Уртнасан,Л. (2018).”Биеийн тамирын хичээлийн үнэлгээний онцлог даалгавар боловсруулах арга зүйн зөвлөмж”. Бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III” сургалтын гарын авлага.УБ.х.53-54.

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

2.1. Бага боловсролын түвшний даалгаврын жишээ, аргачлал

Бага боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөр дэх үнэлгээний зорилт, шалгуур

| Үнэлгээний зорилт | Үнэлгээний шалгуур |
|-----------------------------------|---|
| <i>А. Мэдлэг ойлголт</i> | A1. Биеийн тамирын хэл, нэр томъёо, тэдгээрийн хэрэглээ |
| <i>Б.Мэдлэгээ хэрэглэх чадвар</i> | B1. Өөрийн бие бялдрын хөгжлийн түвшнийг тодорхойлох, сэтгэгдлээ илэрхийлэх байдал B2. Биеийн ерөнхий хөгжлийн дасгалыг гүйцэтгэх байдал B3. Өдөр тутмын амьдралд хэрэгцээт хөдөлгөөний техникийг зөв гүйцэтгэх байдал B4. Төрөл бүрийн дасгал гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа хангах, нөхдөдөө туслах байдал |
| <i>В*. Хандлага</i> | V1. Биеийн тамирын дасгалаар хичээллэх хүсэл сонирхол V2. Биеийн тамирын хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо, идэвх |

Хөтөлбөр дэх I - III, IV -V ангиудын чадварын ялгааг авч үзье.

| Чадвар | Шатлал | |
|--------------------------------|--|--|
| | I - III | IV - V |
| | Ялгаатай байдал | |
| Биеийн ерөнхий хөгжлийн дасгал | Гар, ихбиеийн үндсэн хөдөлгөөнөө мэдэж гүйцэтгэх, өнхрөлт дүүжигнэлтийн дөхүүлэх дасгалыг үздэг. | Гурван цэгийн зогсолт, урагш, арагш өнхрөлт, хосоор өнхрөх гэх мэт үндсэн техникийг үздэг. |
| Алхах, гүйх | Алхах энгийн хувилбар, гүйлт бүхий тоглоомоор тоглох | 50 м, 60 м зайд хурдтай гүйх, гүйлт бүхий тоглоомын дүрмийг баримтлах |
| Үсрэх харайх | Гүйлтээс зураас, намхан саадыг давж харайх | Уртад харайх, өндөрт харайх техникийг гүйцэтгэх |
| Шидэх дамжуулах | Том, жижиг бөмбөгтэй дасгал | Сагсан бөмбөг, волейболын бөмбөг, хөл бөмбөгтэй дасгал гүйцэтгэх |

Иймд I-III, IV-V ангийн үнэлгээний даалгавар өөр өөр байна.

| Шидэх, дамжуулах | Суралцахуйн үр дүнгийн шалгуур | Анги | | |
|--|--|---|--|---|
| | | I | II | III |
| | | Дундзэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж байг онодог. | Жижиг бөмбөг 2-3 м зайнаас өнхрүүлж, газарт байрлуулсан байг онодог. | Янз бүрийн зайд байрлуулсан байг жижиг ба том бөмбөгөөр шидэж онодог. |
| Том бөмбөгөөр шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар хол шиддэг. | Байрнаасаа нэг гараар жижиг бөмбөгийг хол шидэж харуулдаг. | Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргыг оновчтой сонгож, идэвхтэй, үр дүнтэй тоглодог. | | |

- ☑ I-III ангийн шидэлт дамжуулалтын шалгуурыг харахад янз бүрийн бөмбөгөөр өнхрүүлж, шидэж байг онох, жижиг, том бөмбөгийг байрнаас хол шидэх, тоглохдоо дамжуулах аргаа байнга зөв сонгож, тоглоомд идэвхтэй оролцон, ихэнхдээ тоглох гэсэн байна.

| Шидэх, дамжуулах | Суралцахуйн үр дүнгийн шалгуур | Анги | |
|--|--|---|---|
| | | IV | V |
| | | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авдаг. | Сагсан бөмбөгийг хоёр гараар цээжний орчмоос хана руу дамжуулж байг олон шаланд ойлгон барьж авдаг. |
| 150 гр жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс хол шиддэг. | Тэмцээний дүрмийг тайлбарлаж, хурдтай гүйлтээс бөмбөгийг хол шиддэг. | | |

- ☑ IV-V анги бөмбөгийг зүгээр шидэж байг онох биш дамжуулалтаар байг онох, бөмбөгийг гүйлтээс шидэх, бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлдэг болсон, тэмцээнд амжилттай оролцох гэсэн ахисан шатлалтай байна.
- ☑ Бага ангийн үнэлгээн дээр тэр тусмаа I-III ангийн сурагчдыг сайн байна? тааруу байна? гэхээс илүүтэйгээр дасгал хөдөлгөөнийг ойлгох, бие бялдрын хөгжлөө илэрхийлэх, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан харилцах талаас нь мөн үеийнхнээсээ хөдөлгөөний хөгжил нь хоцрогдож байна уу? гэдэг талаас үнэлэх хэрэгтэй.

Бага боловсролын түвшний үнэлгээний аргачлалтай танилцъя.

Үнэлгээний нэгж: Шидэх, дамжуулах (IV анги)

| № | Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр | Суралцахуйн үр дүн |
|---|--|---|
| 1 | 4.4а. Волейболын бөмбөгийг шидэх болон шилжилтээс дамжуулах аргаар хурд-хүчээ хөгжүүлэх | Сурагч бөмбөг дамжуулах чадвараа ашиглан, волейболын бөмбөгийг хана руу оновчтой дамжуулна. |
| | 4.4б. Сагсан бөмбөгийг янз бүрийн бай руу дамжуулах, тоглохдоо оновчтой аргыг сонгох | |
| | 4.4г. Хөл бөмбөгийг хөлөөрөө өнхрүүлэх, тогтоох аргуудыг ашиглах | Сурагч жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулна. |
| | 4.4в. Хүчээ хөгжүүлэхдээ 600-800 гр жинтэй чихмэл бөмбөгийг байрнаас, 150 гр жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулах | |
| | 4.4д. Жижиг бөмбөгөөр 2-5 м зайд буй байг онож, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх, үнэлэх | |


| Суралцахуйн үр дүнгийн шалгуур | Гүйцэтгэлийн хүрэх түвшин | | | |
|---|---|---|---|--|
| | I | II | III | IV |
| Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авдаг. | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа байг цөөн онодог, бөмбөгийг биедээ наан хоёр гараар барьж авдаг. | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа 50%-д нь байг онодог, бөмбөгийг биедээ наан хоёр гараар барьж авдаг. | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа ихэнх тохиолдолд байг онодог, бөмбөгийг хоёр гараар доороос тосон барьж авдаг. | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулах бүртээ байг онодог ба бөмбөгийг хоёр гараар доороос тосон барьж авдаг. |
| 150 гр жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс хол шиддэг. | 10 м зайд хурд багатай гүйж, мэдэгдэм зогсолттойгоор, 150 гр жижиг бөмбөгийг урагш, эсвэл нэлээд дээш чиглэлд шиддэг. | 10 м зайд дунд зэргийн хурдтай гүйж, мэдэгдэм зогсолттойгоор, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж шиддэг. | 10 м зайд хурдтай гүйлтээс, бага зэрэг зогсож, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж, хүчтэй шиддэг. | 10 м зайд хурдтай гүйлтээс, зогсолтгүйгээр, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж, маш хүчтэй шиддэг. |

Дээрх суралцахуйн үр дүнгийн шалгуурт нийцүүлэн 4-р ангийн сурагчдыг хэрхэн үнэлж болохыг доорх жишээгээр үзүүлж байна.

А. Сурагчийн эзэмшсэн мэдлэгийг үнэлэх жишээ

Аман үнэлгээний арга буюу задгай даалгавар.

1. Зураг дээрх “жижиг бөмбөг шидэх” техникийг ажиглан, дараах асуултад хариулж ярина уу?
 - а. Жижиг бөмбөгийг гүйлтээс, алхалтаас, байрнаас шидэхийн аль нь хол шидэх боломж олгох вэ? Яагаад?
 - б. Бөмбөгийг шидэхээр гүйх үедээ бөмбөгөө хаанаа барьж гүйх вэ?
 - в. Бөмбөгийг гараас гаргаж шидэхийн өмнөх алхамуудыг юу гэж нэрлэдэг вэ? Ийм хэдэн алхмыг гүйцэтгэвэл тохиромжтой вэ?
 - г. Бөмбөгийг аль чиглэлд шидвэл тохиромжтой вэ? Эгц урагш уу?, урагш-дээш шидэх үү?



- Сурагчийн асуултад хариулж, дэлгэрүүлэн ярьсан зүйлийн агуулга зөв эсэх, биеийн тамцын хэлээр ойлгомжтой ярьсан байдал зэргийг харгалзан доорх байдлаар үнэлнэ.

| Шалгуур, үнэлгээ | | | |
|---|--|---|--|
| I-II | III-IV | V-VI | VII-VIII |
| 1-2 асуултад зөв хариулсан. 2 асуултыг буруу хариулдаг. | 2-3 асуултад зөв хариулсан. 1 асуултыг хариулаагүй, эсвэл буруу хариулдаг. | 3 асуултад зөв, 1 асуултад дутуу хариулдаг. | 4 асуултыг бүгдийг нь бүрэн зөв хариулдаг. |

Б. Сурагчийн эзэмшсэн хөдөлгөөний чадварыг үнэлэх жишээ

Ажиглан үнэлэх даалгаврын жишээ: IV ангийн үнэлгээний нэгж: Шидэх, дамжуулах

| Үнэлгээний даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|---|--|---|---|---|
| | I-II | III-IV | V-VI | VII-VIII |
| Хананаас 2 м зайд зогсон, волейболын бөмбөгийг хоёр гараар толгой дээрээс хана руу шидэж, 2.5 м өндөрт буй 1x1 м хэмжээтэй байг оноод, доороос хоёр гараар барьж авах | 10 удаа бөмбөгийг хана руу шидээд 8-аас олон удаа байг онодог. | 10 удаа бөмбөгийг хана руу шидээд 6-7 удаа байг онодог. | 10 удаа бөмбөгийг хана руу шидээд 5 удаа байг онодог. | 10 удаа бөмбөгийг хана руу шидээд 3-4 удаа байг онодог. |
| | нэг ч алдалгүйгээр бөмбөгөө хоёр гараар барьж авдаг. | 8-аас олон удаа бөмбөгөө хоёр гараар барьж авдаг. | бөмбөгөө биедээ наан 6-аас олон удаа хоёр гараар барьж авдаг. | бөмбөгөө биедээ наан 5-аас олон удаа хоёр гараар барьж авдаг. |

- ✓ 4-р ангийн “Шидэх, дамжуулах” бүлэгт “Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авдаг” гэсэн суралцахуйн үр дүнгийн шалгуур байгааг дээр харуулсан. Мөн гүйцэтгэлийн 4 түвшинд нийцүүлэн үнэлгээний даалгаврыг хэрхэн боловсруулахыг эндээс тодруулж үзээрэй.
- ✓ Бага ангийн сурагчдын сурах үйл явцыг дэмжих, идэвхжүүлэх нэг арга бол тэднийг үнэлэх явдал юм. Хичээлийн явцын үнэлгээг сурагчидтай хамтран хийх нь тэднийг үнэлгээнд татан оролцуулж буй хэрэг бөгөөд дээрх даалгаврыг нэг сурагч гүйцэтгэх үед нөгөө нь түүнийг ажиглан хэдэн удаа байг онон бөмбөгөө амжилттай барьж авсныг тоолон, багшид мэдээлэх, багштай хамтран гүйцэтгэлийг үнэлэх зэргээр сурагчдыг идэвхжүүлэн ажиллаарай. Сурагч бүрт үнэлгээний даалгаврыг дахин гүйцэтгэж үнэлгээгээ ахиулах боломж олгохыг бодоорой.

Хөдөлгөөний тестээр үнэлэх даалгаврын жишээ:

IV ангийн үнэлгээний нэгж: Шидэх, дамжуулах

| Үнэлгээний даалгавар | Үнэлгээний оноо ба шалгуур | | | |
|--|---|---|---|---|
| | 18-20 оноо | 14-17 оноо | 10-13 оноо | 7-9 оноо |
| 10 м зайнаас гүйж, 150 гр жинтэй жижиг бөмбөгийг хол шидэх | Хурдтай гүйлтээс, бөмбөгөө 10 м-ээс хол шидээд, шидэлтийн шугамыг давж гишгэлгүй зогсдог. | Хурдтай гүйлтээс, бөмбөгөө 8-10 м хол шидээд, шидэлтийн шугамыг давж гишгэлгүй зогсдог. | Дунд зэргийн хурдтай гүйлтээс, бөмбөгөө 6-8 м хол шидээд, шидэлтийн шугамыг давж гишгэлгүй зогсдог. | Хурд багатай гүйж, мэдэгдэм зогсолттойгоор, бөмбөгөө 6 м-ээс холгүй шидээд, шидэлтийн шугамыг давж гишгэлгүй зогсдог. |

- ✓ Дээрх даалгаврыг сурагч гүйцэтгэхдээ жишээ нь, гүйлтээс жижиг бөмбөгийг 8 м хол шидвэл 15 оноо, 9 м хол шидвэл 16 оноо, 10 м хол шидвэл 17 оноо өгч болох боловч бөмбөгөө зөв бариад хэр хурдтай гүйсэн, бөмбөгөө гаргах үедээ зогсолт хийсэн эсэх, шидэлтийн шугамыг давж гишгэсэн эсэх зэргийг харгалзан 1-2 оноог нэмж тооцож болно.

Сурагчдын үнэлгээг тэмдэглэх хуудасны жишээ загвар

| № | Сурагчдын нэрс | Даалгаврын оноо | | | | | | | | | | | | Авсан оноо | Гүйцэтгэлийн хувь |
|-------------------|----------------|--|--------|------|----------|---|--------|------|----------|--|--------|------|----------|------------|-------------------|
| | | Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн мэдлэг | | | | Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авах | | | | 10 м зайнаас гүйж, 150 гр жинтэй жижиг бөмбөгийг хол шидэх | | | | | |
| | | I-II | III-IV | V-VI | VII-VIII | I-II | III-IV | V-VI | VII-VIII | I-II | III-IV | V-VI | VII-VIII | | |
| 1 | Б.Б | | | | | | | | | | | | | | |
| 2 | Б.А | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | | |
| Гүйцэтгэлийн хувь | | | | | | | | | | | | | | | |

Дээрх хүснэгтэд сурагч даалгаврыг аль түвшинд хийж гүйцэтгэсэнийг түвшнийг тэмдэглэнэ. Ингэснээр хэн гэдэг сурагч ямар ямар даалгавар дутуу байгааг илрүүлэн даалгаврыг гүйцэтгүүлнэ.

У АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ: ШИДЭХ, ДАМЖУУЛАХ

Тавдугаар ангийн сурагчдын шидэх хэрэгслийн жин нь өмнөх ангиудынхаас бага зэрэг нэмэгдэх ёстой. Тиймээс энэ ангид жинхэнэ сагсан бөмбөг, волейболын бөмбөг, хөл бөмбөгийг шидэх, дамжуулах, өшиглөх дасгалд өргөн ашиглана.

Үнэлгээний нэгж (unit assessment) ШИДЭХ, ДАМЖУУЛАХ

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур | Гүйцэтгэлийн хүрэх түвшин | | | |
|--|---|---|---|--|
| | I | II | III | IV |
| Сагсан бөмбөгийг хоёр гараар цээжний орчмоос хана руу дамжуулж байг онон, шаланд ойлгон барьж авдаг. | 2 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг цөөн удаа оновчтой гүйцэтгэдэг. | 2 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг цөөн удаа оновчтой гүйцэтгэдэг. | 2.5 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг олон удаа оновчтой гүйцэтгэдэг. | 3 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг олон удаа оновчтой, зөв гүйцэтгэдэг. |
| Сурагч жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэн, тэмцээнд оролцдог. | Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг багшийн ба нөхдийнхөө тайлбараар хэрэгжүүлэн тэмцээнд оролцдог. | Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэхдээ анхааруулга авдаг, тэмцээнд оролцож, өөрийн амжилтаа бататгадаг. | Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэн, тэмцээнд оролцож, өөрийн амжилтаа ахиулдаг. | Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг бүрэн хэрэгжүүлж, тэмцээнд амжилттай оролцон, тэргүүн байруудыг эзэлдэг. |

А. Сурагчийн ойлголт мэдлэг ба хөдөлгөөний чадварыг үнэлэх жишээ


1. Доорх дасгалуудыг уншаад, хосоороо биеэр гүйцэтгэж үзүүлнэ үү?
 - а. Хоорондоо зайтай өөд өөдөөсөө харж зогссон байдлаас цээжний орчмоос хоёр гараар бие бие рүүгээ бөмбөгийг шаланд ойлгон дамжуулах.
 - б. Бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар хана руу дамжуулаад, шаланд ойлгон барьж авах.

☑ *Багш дээрх даалгаврын гүйцэтгэлийг доорх хүснэгтийг ашиглан оноожуулна. Сурагчийн даалгаврыг биелүүлсэн байдлыг тухайн үзүүлэлтэд харгалзуулан оноог тэмдэглэнэ.*



| № | Сурагчдын нэрс | Бичвэрийг уншаад ойлгосон байдал | | | | Дасгалыг биеэр үзүүлсэн байдал | | | | Авсан оноо |
|---|----------------|----------------------------------|---------------|---------------------|-----------|--------------------------------|------------------|------------------------|--------------------|------------|
| | | Маш сайн ойлгосон | Сайн ойлгосон | Дунд зэрэг ойлгосон | Ойлгоогүй | Маш сайн гүйцэтгэсэн | Сайн гүйцэтгэсэн | Дунд зэрэг гүйцэтгэсэн | Тааруу гүйцэтгэсэн | |
| 1 | А | | | | | | | | | |
| 2 | Б | | | | | | | | | |
| 3 | Ц | | | | | | | | | |

Бичгийн даалгавар

1. Сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулахдаа бөмбөгийг яаж барих вэ? /1 оноо/
 - а. Бөмбөгийг барихдаа хоёр гарын эрхий хуруу бие бие рүүгээ чиглэсэн, ижил түвшинд байх бусад хуруунууд урагш дээш байрлалтай байна.
 - б. Бөмбөгийг барихдаа хоёр гарын эрхий хуруу хажуу дээш чиглэсэн байх бусад хуруунууд урагш дээш байрлалтай байна.
 - в. Бөмбөгийг барихдаа хоёр гарын эрхий хуруу бие бие рүүгээ чиглэсэн байх бусад хуруунууд хажуу тийш байрлалтай байна.
2. Хөл бөмбөгийг улаар тогтоох арга аль нь вэ? /1 оноо/




3. Зураг дээр хөл бөмбөгийг ямар аргаар өшиглөж байна вэ? /1 оноо/



- а. Бөмбөгийг шагайн дотор талаар өшиглөх
- б. Бөмбөгийг шагайн дотор талаар тогтоох
- в. Бөмбөгийг өлмий хэсгээр өшиглөх

4. Зураг дээр сагсан бөмбөгийг ямар аргаар дамжуулж байна вэ? /1 оноо/



- а. Бөмбөгийг хоёр гараар дамжуулах
 - б. Сагсан бөмбөгийг цээжний орчмоос дамжуулах
 - в. Сагсан бөмбөгийг мөрний орчмоос хоёр гараар дамжуулах
5. Өнхөрч ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоохдоо биеийн хүндийн төвөө аль хөл рүү шилжүүлэх вэ? /1 оноо/
- а. Биеийн хүндийн төвөө тулгуур хөл рүү шилжүүлэх
 - б. Биеийн хүндийн төвөө баруун хөл рүү шилжүүлэх
 - в. Биеийн хүндийн төвөө зүүн хөл рүү шилжүүлэх

Б. Сурагчийн эзэмшсэн хөдөлгөөний чадварыг үнэлэх жишээ

Ажиглан үнэлэх даалгаврын жишээ: V ангийн үнэлгээний нэгж: Шидэх, дамжуулах

| Үнэлгээний даалгавар | Үнэлгээ | | | |
|--|--|--|--|--|
| | 5 оноо | 6-7 оноо | 8-9 оноо | 10 оноо |
| Хананаас 2-3 м зайнаас сагсан бөмбөгийг хоёр гараар цээжний орчмоос дамжуулан, хананд буй 1x1 м байг онож, бөмбөгийг шаланд ойлгон барьж авах – 5 удаа | Бөмбөгөө 2 м зайнаас 2-3 удаа оновчтой дамжуулан, шаланд ойлгож барьж авдаг. | Бөмбөгөө 2 м зайнаас 4-5 удаа оновчтой дамжуулан, шаланд ойлгож барьж авдаг. | Бөмбөгөө 2.5 м зайнаас 4-5 удаа оновчтой дамжуулан, шаланд ойлгож барьж авсан. | Бөмбөгөө 3 м зайнаас 5 удаа оновчтой дамжуулан, шаланд ойлгож барьж авсан. |

☑ *Багш нэр хүүхдийн тооноос хамааран дамжуулалтын тоог ихэсгэж, багасгаж болно. Хэрэв тэгвэл үнэлгээний оноогоо өөрчлөөрэй.*

| Үнэлгээний даалгавар | Үнэлгээ | | | |
|---|--|--|--|--|
| | 2-3 оноо | 4-5 оноо | 6-7 оноо | 8-10 оноо |
| Гүйлтээс 150 г жинтэй жижиг бөмбөг шидэлтийн ангийнхаа тэмцээнд оролцох | Тэмцээний дүрмийг багшийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж, тэмцээнд оролцон, 10-аас хойш байр эзэлсэн. | Тэмцээний дүрмийг багшийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж, тэмцээнд оролцон, 7-9-р байр эзэлсэн. | Тэмцээний дүрмийг бие даан хэрэгжүүлж, тэмцээнд амжилттай оролцон, 4-6-р байр эзэлсэн. | Тэмцээний дүрмийг бие даан хэрэгжүүлж, тэмцээнд амжилттай оролцон, 1-3-р байр эзэлсэн. |

- ✓ Тэмцээний арга нь биеийн тамирын сургалтын үнэлгээний тусгай арга мөн. Тавдугаар ангийн сурагчид гүйлтээс жижиг бөмбөгийг хол шидэх чадвартай болсон байх тул энэ төрлөөр анги дотор тэмцээн зохион байгуулна. Үүнийг эртнээс зарлаж, сурагч бүрийн бэлтгэлийг хангуулах хэрэгтэй. Тэмцээний өмнөх 2-оос цөөнгүй цагийн хичээл дээр бөмбөгийг хол шидэх чадварыг сайжруулахад чиглэсэн дасгалуудыг өгсөн байвал зохино. Сурагчдын тооноос хамаарч сурагчийн тэмцээнд эзлэх байранд өгөх оноог өөрчилж болно.

2.2. Суурь боловсролын түвшний даалгавар, аргачлал

Суурь боловсролын түвшинд наймдугаар ангийн “Хөнгөн атлетик” нэгжийн жишээн дээр даалгавар боловсруулсан. Сурагчдыг үнэлэхдээ спортын тодорхой төрлийг судлах явцад тухай төрлийн дасгалын техник эзэмшилт, дасгалыг гүйцэтгэх хурд, хүч, далайц, тэмцээний амжилт зэргийг харгалзан гаргасан ахиц, үр дүнг үнэлнэ.


Сургалтын хөтөлбөр дэх үнэлгээний зорилт, шалгуур

| Үнэлгээний зорилт | Үнэлгээний шалгуур |
|-----------------------------|--|
| А. Мэдлэг ойлголт | <ul style="list-style-type: none"> - Дасгалын зөв нэр томъёо, биеийн тамирын ухагдахуун, дасгалын зураг дүрслэл - Судалж буй спортын дасгалын гүйцэтгэлийн техник ба гарч болзошгүй алдаа - Судалж буй спортын төрлийн тэмцээний дүрэм - Бие бялдрын хөгжил, чийрэгжилтээ тодорхойлох арга |
| Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар | <ul style="list-style-type: none"> - Бие бялдрын хөгжлөө хэмжиж, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, өөрийн үнэлгээ өгөх, тайлбарлах - Өөрийн бие бялдрын хэрэгцээнд тохируулан дасгалыг сонгох, сонгосон дасгалаа зөв гүйцэтгэх - Судалж буй спортын төрлийн техникийг гүйцэтгэх - Хүч, хурд, тэсвэр, хөдөлгөөний эвсэл, уян хатан, тэсвэрийн үзүүлэлтээ ахиулах |
| В. Хандлага | <ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн дасгалыг хичээн хийж, илүү зөв гүйцэтгэхийн төлөө зүтгэл - Спортоор хичээллэх хүсэл сонирхол - Биеийн тамирын хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо, идэвх - Хожих, хожигдох үед сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл |

Үнэлгээний жин

| Үнэлгээний зорилт | Эзлэх хувийн жин |
|--|------------------|
| А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар | 30% |
| Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар | 70% |

Үнэлгээний төлөвлөгөө боловсруулах:



VIII ангийн Хөнгөн атлекийн нэгж дээр даалгаврын жишээ, аргачлал

Хөнгөн атлекийн бүлэг сэдвийг гүйлт, харайлт, шидэлт гэсэн гурван нэгжид хуваасан. Эдгээр гурван нэгжийг нэгтгэн дүгнэх боломжгүй юм. Иймд нэгж тус бүрээр нь үнэлнэ.

Үнэлгээний нэгж (unit assessment) ХӨНГӨН АТЛЕТИК

| № | Суралцахуйн үр дүн | Суралцахуйн үр дүнгийн шалгуур |
|---|--|--|
| 3 | Сурагч 4x60 м буухиалан гүйж, 800-1000 м зайд спорт алхаагаар уралдан алхаж харуулна. | 4x60 м буухиад уралдаж гүйхдээ “доороос” дамжуулалтын техникийг ашигладаг. 800-1000 м зайд спорт алхаагаар уралдахдаа өөрийгөө дайчилж өрсөлдөгчөө ялахын төлөө хичээдэг. |
| | Сурагч өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг тодорхойлон, бүтэн гүйлтээс өндөрт уг техникээр харайж харуулна. | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэн, бүтэн гүйлтээс өндөрт уг техникээр харайдаг. |
| | Сурагч 150 г жинтэй жижиг бөмбөгийг хол шидэж харуулна. | 150 г жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс аль болох хол шиддэг. |

Үнэлгээний нэгж (unit assessment) ХӨНГӨН АТЛЕТИК

| № | Суралцахуйн үр дүнгийн шалгуур | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|--|---|--|---|--|
| | | I | II | III | IV |
| 1 | 4x60 м буухиад уралдаж гүйхдээ “доороос” дамжуулалтын техникийг ашигладаг. | 4x60 м гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах ба хүлээн авахдаа том алдаа гаргасан, зайн гүйлтэд дунд зэргийн хурдтай гүйдэг. | 4x60 м гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах ба хүлээн авахдаа нэлээд алдаа гаргасан, зайн гүйлтэд дунд зэргийн хурдтай гүйдэг. | 4x60 м гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах ба хүлээн авахдаа хурдаа сааруулсан, зайн гүйлтэд хурдтай гүйдэг. | 4x60 м гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах ба хүлээн авах техникийг зөв гүйцэтгэсэн, зайн гүйлтэд хурдтай гүйдэг. |
| 2 | Босоо гараанаас 2000 м зайд жигд гүйдэг. | Босоо гараанаас 2000 м зайд туулахдаа нийт зайн 50%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг. | Босоо гараанаас 2000 м зайд туулахдаа нийт зайн 30-40%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг. | Босоо гараанаас 2000 м зайд жигд бус хурдаар гүйж туулдаг. | Босоо гараанаас 2000 м зайд жигд хурдаар гүйж туулдаг. |

| | | | | | |
|---|---|--|---|---|---|
| 3 | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэн, бүтэн гүйлтээс өндөрт уг техникээр харайдаг. | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м-ээс дунд зэргийн хурдтай гүйх, түлхэх, савах, буух техникт олон алдаа гаргасан, тодорхой өндрийг давж чадаагүй. | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м-ээс хурдтай гүйж, тодорхой өндрийг давахдаа техникийг нэлээд алдаатай гүйцэтгэдэг. | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м-ээс хурдтай гүйж, түлхэлтийн хөлөөр хүчтэй түлхэхдээ савалтын хөлийг шулуунаар дээш савж хөндлөвч давуулан, түлхэлтийн хөлөө татаж авах техникийг цөөн алдаатай үзүүлж, тодорхой өндрийг давдаг. | Өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м-ээс хурдтай гүйж, түлхэлтийн хөлөөр хүчтэй түлхэхдээ савалтын хөлийг шулуунаар дээш савж хөндлөвч давуулан, түлхэлтийн хөлөө татаж авах техникийг маш зөв үзүүлж, тодорхой өндрийг давдаг. |
|---|---|--|---|---|---|

1. Хөдөлгөөний тестээр үнэлэх даалгаврын жишээ: VIII ангийн хөнгөн атлетик

| Үнэлгээний даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|---|--|---|--|---|
| | 61-70 | 71-80 | 81-90 | 91-100 |
| 150 г жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэх | Хөвгүүд 10 м-ээс наана шидсэн. Охид 9 м-ээс наана шидсэн | Хөвгүүд 10-11 м хол шидсэн. Охид 8-9 м хол шидсэн | Хөвгүүд 11-12 м хол шидсэн. Охид 9-10 м хол шидсэн | Хөвгүүд 12 м-ээс хол шидсэн. Охид 10 м-ээс хол шидсэн |

✓ Энэ жишээн дээр 5-р ангийн суралцахуйн үр дүнгийн шалгуурт баримжаалан, гүйлтээс бөмбөг шидэлтийн ангийн дундаж түвшнийг хөвгүүдэд 12 м, охидод 10 м гэж тооцов. Эндээс жишээлэн та өөрийн ангийн дундаж түвшинд нийцүүлэн үнэлгээний шалгуурыг өөрчлөн боловсруулж, сурагчдын үнэлгээнд ашиглахыг анхаарна уу?

2. Нормоор үнэлэх даалгаврын жишээ: VIII ангийн сурагчдын дунд, холын зайд гүйх чадварын үнэлгээ

| Даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|--|--|---|--|---|
| | 61-70 | 71-80 | 81-90 | 91-100 |
| Охид 1500 м, хөвгүүд 2000 м зайд жигд хурдаар гүйх | Алхах, гүйхийг хослуулахдаа охид 750 м, хөвгүүд 1000 м зайд алхаж, үлдсэн зайг гүйж дуусгасан. | Алхах, гүйхийг хослуулахдаа охид 450-600 м, хөвгүүд 600-800 м зайд алхаж, үлдсэн зайг гүйж дуусгасан. | Жигд бус хурдаар гүйсэн боловч алхалгүй гүйж зайг дуусгасан. | Замдаа нэг ч зогсолгүй, алхалгүй, жигд гүйж зайгаа дуусгасан. |

✓ Тэсвэрийн гүйлтийн чадварыг үнэлэхдээ дээрх зайд гүйсэн хугацааг хэмжихгүйгээр зөвхөн замдаа зогсохгүй гүйх чадварыг үнэлж байна. Ингэж хол зайд жигд гүйх чадвар эзэмшсэний дараа цаашид та гүйлтийн хугацаагаар үнэлгээний норм тогтоож сурагчдыг үнэлж болно.

| Даалгавар | Хүйс | Шалгуур, үнэлгээ | | | |
|-----------------------------|---------|------------------|-------------|-------------|-------------|
| | | 61-70 | 71-80 | 81-90 | 91-100 |
| Нам гараанаас 60 м гүйх /с/ | Охид | 13.3 - 14.2 | 12.3 - 13.2 | 11.3 - 12.2 | 11.2 - доош |
| | Хөвгүүд | 12.7 - 13.6 | 11.7 - 12.6 | 10.7 - 11.6 | 10.6 - доош |

- ✓ 60 м зайд охид, хөвгүүдийг хугацаатай гүйлгэж, багш норм тогтоож үнэлнэ. Уг нормыг нарийвчлан боловсруулах боломжтой. Биеийн тамцын хичээлийн жилийн төлөвлөгөөнд хөнгөн атлетийн хичээлийг дулаан цагт намар, хавартаа төлөвлөдөг. Тиймээс хичээлийн эхэнд ба төгсгөлд сурагчийн гүйсэн амжилтыг харьцуулан ахицаар нь үнэлж бас болох юм.

3. Тэмцээнээр үнэлэх даалгаврын жишээ:

Ойрын зайн гүйлтийн тэмцээнд оролцож гүйх. Тэмцээнд орсон сурагчдыг амжилт, оролцоогоор нь үнэлж болно.

Багшийн тэмдэглэлийн жишээ загвар

| № | Сурагчдын нэрс | Анги бүлэг | Оролцооны тоо | | |
|---|----------------|------------|-----------------------|--------------|--------------------|
| | | | Тэмцээнд оролцсон тоо | Эзэлсэн байр | Нэмэлт онооны хувь |
| 1 | Сондор | 8д | 2 | II, III | 10 |
| 2 | Тэнгис | 8д | | | |
| 3 | Төгсбилэг | 8д | | | |
| 4 | Мөнхтулга | 8д | 1 | IV | 7 |
| 5 | Тэлмэн | 8д | 3 | I, IV, VI | 10 |

Сурагчдад өгөх үнэлгээ

| Оролцоо | Тухайн зайд гүйсэн сурагчдын эзэлсэн байр | Хувь |
|----------------------------|---|--------|
| Тэмцээнд оролцсон сурагчид | 1-3-р байр | 91-100 |
| | 4-5-р байр | 81-90 |
| | 6-7-р байр | 71-80 |
| | 8-10-р байр | 61-70 |

- ✓ Хүүхдийн сонирхол хүсэл эрмэлзэл, тэмцээний тоо, хүүхдийн оролцох тоо хязгаартай. Иймд энэ аргаар сурагчдыг үнэлэхдээ тэмцээнд оролцсон сурагчдын тоог анхаарч шалгуураа боловсруулна. Сурагч болгон тэмцээнд оролцох боломжгүй байдаг. Тэмцээнд оролцох боломжгүй сурагчид багшийн туслахаар ажиллах ба багшид туслахдаа гүйлтийн тэмцээний дүрмийг ойлгож, хэрэгжүүлсэн байдлыг харгалзан тэдэнд үнэлгээ өгөөрэй.

4. Хөдөлгөөний тестээр үнэлэх даалгаврын жишээ:

| Даалгавар | Амжилт, см | | Үнэлгээний хувь | Түвшин |
|---------------------|------------|-----------|-----------------|------------|
| | Охид | Хөвгүүд | | |
| Өндөрт алхаж харайх | 85 – 90 | 105 – 110 | 90 – 100 | VII – VIII |
| | 75 – 80 | 95 – 100 | 80 – 89 | V - VI |
| | 65 – 70 | 85 – 90 | 70 – 79 | III - IV |
| | 55 – 60 | 75 – 80 | 60 – 69 | I - II |

- ✓ Багш тухайн орон нутгийнхаа онцлог, хүүхдийн нас биеийн онцлог чадварт нь тохируулан үнэлгээний тестээ боловсруулахыг анхаарах. Хөдөлгөөний тестийн гүйцэтгэлийг нормоор болон ахицаар үнэлэх боломжтой.

Бичгийн тестийн даалгавар №2

1. Гүйлтийн төрлийн зайг зөв харгалзуулна уу? /3 оноо/

- | | | |
|----------------------|--------------------------|---------------|
| 1. Ойрын зайн гүйлт | а. 800м, 1500м | |
| 2. Дундын зайн гүйлт | б. 100м, 200м, 400м | |
| 3. Холын зайн гүйлт | в. 5000м, 10000м, 15000м | |
| А. 1а, 2б, 3в | Б. 1б, 2а, 3в | В. 1б, 2а, 3б |

2. Нам гарааны техникийг зөв харгалзуулна уу? /4 оноо/

1. Нам гарааны байрлал

а.



2. Гараандаа

б.



3. Анхаар

в.



4. Марш

г.

**А. 1г, 2в, 3б, 4а**

Б. 1а, 2в, 3а, 4б

В. 1б, 2а, 3б, 4г

3. Босоо гарааны техникийг зөв харгалзуулна уу? /3 оноо/


1. Гараандаа

а.



2. Марш

б.



3. Бариа

в.




А. 1а, 2в, 3б

Б. 1б, 2а, 3в

В. 1б, 2в, 3а

4. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү? /2 оноо/
 Өндөрт “алхаж” харайх техник нь дараах 4 хэсгээс бүрдэнэ.
 а. Урьдчилсан гүйлт
 б. Түлхэлт
 в.
 г.
5. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү? /1 оноо/
 Буухиа гүйлтийн тэмцээний үед буухианы модыг метр бүс дотор дамжуулна.
6. Шидэлтийн төрлүүдийг зөв харгалзуулна уу? /3 оноо/
 1. Гранат шидэлт
 2. Гүйлтээс бөмбөг шидэлт
 3. Жад шидэлт



A. 1б, 2в, 3а

Б. 1а, 2в, 3б

В. 1б, 2а, 3б

7. Буухиа модыг дамжуулах хоёр техникийг бичнэ үү? /2 оноо/
 а.
 б.
8. Буухиа гүйлтийн тэмцээний 2 зайг бичнэ үү? /2 оноо/
 1.
 2.

Бичгийн тест №2-ын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

| Оноо | Хувь | Түвшин |
|------|------|--------|
| 20 | 100 | VIII |
| 19 | 95 | |
| 18 | 90 | |
| 17 | 85 | VII |
| 16 | 80 | |
| 15 | 75 | VI |
| 14 | 70 | |
| 13 | 65 | V |
| 12 | 60 | |
| 11 | 55 | IV |
| 10 | 50 | |
| 9 | 45 | III |
| 8 | 40 | |
| 7 | 35 | II |
| 6 | 30 | |
| 5 | 25 | I |

- ✓ Нөхөх даалгавар боловсруулахдаа анхаарах зүйлс: Өгүүлбэрээс цөөн хэдэн үгийг хасах нь зохистой бөгөөд хэтэрхий олон үг хасах нь тодорхойгүй байдлыг бий болгодог. Хоосон хэсгийг илгээх зураасын урт нь бусад бүх өгүүлбэр, эсвэл асуултуудын урттай ижил байдлаар оруулах хэрэгтэй. Урт богино байвал сэжүүр өгч буй мэт ойлголт төрүүлдэг.
- ✓ Сурагчдыг бүх даалгавраа өгсөн гэдгийг оноожуулах хэрэгтэй юм. Оноожуулах хуудсыг багш хэрэглэнэ. Сурагч бүрт ийм үнэлгээний хуудас байвал өөрийн үнэлгээг мэдэж байхын зэрэгцээ үнэлгээгээ ахиулах боломжийг эрж хайн үнэлгээнд бэлтгэх болно.

“Хөнгөн атлетик” үнэлгээний нэгжийн эцсийн үнэлгээний жишээ

| № | Сурагчдын нэрс | 1500-2000 м жигд гүйх | Нам гараанаас 60 м гүйх | Өндөрт алхаж харайх | Бичгийн тестийн даалгавар | | Дундаж хувь |
|--------------------|----------------|-----------------------|-------------------------|---------------------|---------------------------|----|-------------|
| | | | | | №1 | №2 | |
| 1 | Сондор | 80 | 71 | 75 | 88 | 85 | 80 |
| 2 | Тэнгис | | | | | | |
| 3 | Төгсбилэг | | | | | | |
| 4 | Мөнхтулга | | | | | | |
| 5 | | | | | | | |
| Ангийн дундаж оноо | | | | | | | |

- ✓ Сурагчдын шалгуур бүрээр авсан онооны дүнг нэгтгэн, сурагчид ямар түвшинд байгааг тодорхойлно. Мөн сурагчдын ямар даалгавар дутуу байгааг харах боломжтой, дутуугаа гүйцээх боломж олгох юм. Эндээс мөн ангийн дундаж үзүүлэлтийг харж, багш сургалтын ажлаа цаашид төлөвлөх мэдээллийг авна.

2.3. Бүрэн дунд боловсролын түвшний даалгавар, аргачлал

Бүрэн дунд боловсролын түвшинд аравдугаар ангийн “Сагсан бөмбөг”-ийн нэгжийн жишээн дээр даалгавар боловсруулсан. Сагсан бөмбөг сэдвээр эзэмшсэн сурагчийн мэдлэг чадварын 70% нь ур чадвар, 30% нь онолын мэдлэгээр үнэлнэ. Сагсан бөмбөгийн үндсэн техникийг эзэмшихийн эцсийн үр дүн бол бөмбөгийг оновчтой дамжуулах, шидэлтийг амжилттай гүйцэтгэх, бөмбөгийг алдахгүйгээр залж сурах юм.

Үнэлгээний нэгж (unit assessment) САГСАН БӨМБӨГ (жишээ)

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН | | | |
|---|---|--|--|--|
| | I | II | III | IV |
| Хуурмаг хөдөлгөөний аргуудыг зөв сонгож гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний нэг арга мэддэг боловч түүнийгээ алдаатай гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний нэг аргыг зөв гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний аргуудаас заримыг нь зөв гүйцэтгэдэг. | Хуурмаг хөдөлгөөний аргуудыг бүгдийг зөв гүйцэтгэдэг. |
| Сагсан бөмбөгийн залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулан үр дүнтэй гүйцэтгэдэг | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулахдаа зогсолттой, оновчтой биш гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулахдаа дунд зэргийн хурдтай, заримдаа оновчтой гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь хослуулан, хурдтай, оновчтой гүйцэтгэдэг. | Залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг хооронд нь зөв хослуулан, маш оновчтой, өндөр хурдтай гүйцэтгэдэг. |

| | | | | |
|--|--|--|--|--|
| Сагсан бөмбөг тоглохдоо довтолгоо, хамгаалалтын энгийн тактикийг ашигладаг. | Бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан довтолгоо оролдлого хааяа хийдэг. Хувийн хамгаалалтаар довтолгоогчийг хамгаалахыг оролддог. Бүлгийн хамгаалалтыг буруу, идэвхгүй гүйцэтгэдэг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан довтолгоо гүйцэтгэдэг. Хувийн хамгаалалтаар довтолгоогчийг хамгаалахыг оролддог. Бүлгийн хамгаалалтад заримдаа байрлалаа буруу эзэлснээс алдаа гаргадаг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан үр дүнтэй довтолдог. Хувийн хамгаалалтаар довтолгоогчийг хамгаалдаг. Бүлгийн хамгаалалтад байрлалаа зөв эзэлдэг боловч хамгаалахдаа алдаа гаргадаг. | Хувийн ба бүлгийн довтолгооны энгийн тактикийг ашиглан үр дүнтэй довтолдог. Хувийн ба бүлгийн хамгаалалтын энгийн тактикийг оновчтой ашиглан довтолгоогчийг хамгаалж чаддаг. |
| Сагсан бөмбөг тоглохдоо дүрмийн мэдлэгээ ашиглан, шүүгчийн дохио заалтыг хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтыг багшийн ба нөхдийнхөө дэмжлэгтэй ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтын цөөнхийг ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтын ихэнхийг ойлгож, хэрэгжүүлдэг. | Сагсан бөмбөг тоглох үедээ шүүгчийн заалтыг бүгдийг ойлгодог, заалт бүрийг хэрэгжүүлдэг. |

- ✓ *Хамгаалагч биеийнхээ хүндийн төвийг хуурмаг хөдөлгөөний чиглэлд шилжүүлж эхэлмэгц, бөмбөгтэй тоглогч биеийн жингийнхээ хүндийн төвийг ард тавьсан хөл дээрээ шилжүүлэн нөгөө хөлөөрөө эсрэг чиглэлд алхам хийж залалтад шилжсэнээр хамгаалан тоглогчоос мултарч чадаж байна уу? гэсэн үндсэн залалтын техникүүдийг хооронд нь зөв хослуулан, маш оновчтой, өндөр хурдтай гүйцэтгэж чадаж байна уу? гэдгийг багш ажиглаж, үнэлэхийг анхаарах.*
- ✓ *Дамжуулалтыг гүйцэтгэхэд хамгаалагчийн өндөр ба нам байрлал, хамгаалалтын тактикаас шалтгаалдаг. Хэрвээ хамгаалагч ойрхон байвал хуурах (дохио, зангах), хамгаалагч гараа өргөөгүй буюу намхан хамгаалагчийн толгой дээгүүр, хамгаалагч ойрхон байрлалтай зогссон байвал шалаар, хамгаалагч хол байрлалд байгаа буюу дамжуулалтыг таслах боломжгүй үед эгц шулуун гэх мэт дамжуулалтын техникүүдийг хооронд нь зөв хослуулан, маш оновчтой, өндөр хурдтай гүйцэтгэж чадаж байна уу? гэдгийг багш ажиглаж, үнэлэхийг анхаарах.*
- ✓ *Цагаригт бөмбөг шидэх дуураймал буюу хуурмаг хөдөлгөөнийг хийхдээ тоглогч цагаригт шидэлт гүйцэтгэхээр төлөвлөсөн мэт хуурмаг хөдөлгөөн үзүүлээд дараа нь хамгаалагчаас мултран гарч залалтад шилжих эсвэл дамжуулах буюу хамгаалан тоглогч хуурмагц шидэлтийг бас хийдэг. Эдгээр техникийг гүйцэтгэж чадаж байна уу? гэдгийг багш ажиглаж үнэлнэ¹⁰.*

¹⁰ Уртнасан,Л., Бат-Отгон, Б.,Уранмандах,Д., Гантулга,А.,Энхтөр,М.(2018). Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III. Улаанбаатар. БМДИ. х.22-23.

Сагсан бөмбөг нэгжээр сурагчийн үр чадварыг үнэлэх үнэлгээний даалгавар

Даалгавар-1. Ажиглаж үнэлэх даалгаврын жишээ:

| Үнэлгээний даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|--|--|---|--|---|
| | I-II | III-IV | V-VI | VII-VIII |
| Довтлогч бөмбөг барин хамгаалагч руу нуруугаа харуулан, хөлдөө мөрний хэмжээтэй зогссон байдлаас аль нэг тийш 90 хэмээс багагүй эргэлт хийн, хөлийг урагш тавьж бөмбөгийг дамжуулах хөдөлгөөн хийгээд буцаад эргэлт хийн бөмбөгийг залж гүйнэ. Энэ үед хамгаалагч гараа алдлан зогсож байх ба зөвхөн довтлогчийн хийсэн хуурмаг хөдөлгөөнийг үнэлнэ. | Эргэлт хийх үед тулгуур хөл газраас хөндийрсөн, бөмбөгийг дохих хөдөлгөөн хийгээгүй. | Эргэлт хийх үед тулгуур хөл газраас хөндийрөөгүй, бөмбөгийг дохих хөдөлгөөн хийгээгүй, эхний эргэлтийг дутуу гүйцэтгэдэг. | Эргэлт хийх үед тулгуур хөл газраас хөндийрөөгүй, бөмбөгийг дохих хөдөлгөөн хийсэн, сүүлийн эргэлтийг дутуу гүйцэтгэдэг. | Эргэлт хийх үед тулгуур хөл газраас хөндийрөөгүй, бөмбөгийг дохих хөдөлгөөн хийсэн, эргэлтүүдийг гүйцэд алдаагүй зөв гүйцэтгэдэг. |

- ✓ Тухайн орон нутгийн нөхцөл байдал, сурагчдын бие бялдрын онцлогт тохируулан байны тойргийн хэмжээ, дамжуулах зай, шидэх зай, суралцахуйн үр дүнгийн шалгуурыг өөрчлөн хэрэглэж болно.

Даалгавар-2. Нормоор үнэлэх жишээ

| Үнэлгээний даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|---|---|----------|----------|-----------|
| | I-II | III-IV | V-VI | VII-VIII |
| Сагсан бөмбөгийг 9 м залан гүйж, хананд байрлуулсан 40 см диаметртэй бай руу 4 м зайнаас 3 удаа дамжуулаад, дахин бөмбөгийг залан гүйж, торгуулийн шугам дээр тавьсан 3 бөмбөгийг авч цагаригт шиднэ. | 3-4 оноо | 5-6 оноо | 7-8 оноо | 9-10 оноо |
| | <ul style="list-style-type: none"> - Оновчтой дамжуулалт бүр 1 оноо - Оновчтой шидэлт бүр 1 оноо Уг даалгаврыг 40 секундэд гүйцэтгэвэл – 4 оноо, 41-45 с – 3 оноо, 46-50 с – 2 оноо, 51-ээс дээш с – 1 оноо өгнө. | | | |

- ✓ Даалгавруудын зөв гүйцэтгэл, хугацаа, эцсийн үр дүн дээр л анхаараарай.

Даалгавар-3

| Үнэлгээний даалгавар | Шалгуур, үнэлгээ | | | |
|--|---|------------|------------|------------|
| | I-II | III-IV | V-VI | VII-VIII |
| 10 м урт талбайд тавьсан 5 ширхэг тугийг сүлжин бөмбөгөө залан гүйж, хананаас 3 м зайнаас, 150 см өндөрт байрлуулсан 40 см диаметртэй бай руу 5 удаа дамжуулна. Бөмбөгийг ойлгохгүй барьж авна. Дамжуулалтын дараа тугийг буцаж сүлжээд 2 алхамтаас цагаригт бөмбөгийг шиднэ. Бөмбөгийг заавал цагаригт оруулсан тохиолдолд цаг зогсоно. | 11-ээс доош оноо | 12-15 оноо | 16-19 оноо | 20-22 оноо |
| | <ul style="list-style-type: none"> - 5 ш тэмдэгтийг бүгдийг сүлжиж гүйсэн ба тэмдэгтийг унагаагүй бол 5 оноо - 5 удаа хана руу оновчтой дамжуулсан ба шугам гишгээгүй бол 5 оноо - Буцаж 5 ш тэмдэгтийг бүгдийг сүлжиж гүйсэн ба тэмдэгтийг унагаагүй бол 5 оноо - Хоёр алхамтаас бөмбөгийг эхний шидэлтээр оруулсан бол 1 оноо - Уг даалгаврыг гүйцэтгэсэн хугацаа: <ul style="list-style-type: none"> хөвгүүд 16 с, охид 19 с-ээс доош бол 4 оноо хөвгүүд 16.1-17.0 с, охид 19.1-20.0 с бол 3 оноо хөвгүүд 17.1-18.0 с, охид 20.1-21.0 с бол 2 оноо хөвгүүд 18.1 с, охид 21.1 с-ээс дээш бол 1 оноо | | | |

4. Тоглолтын үед бөмбөгийг залж байгаад бариад дахин залж болох уу?

А. Болно.

Б. Болохгүй

5. Шүүгчийн заасан алдааг тайлбарлаарай.



А. Бөмбөгийг хөлний хажуугаар залсан

Б. Хөлөөр бөмбөгийг гаргасан

В. Хөл оролцуулан тоглосон

Г. Илүү алхам хийсэн

6. Шүүгчийн заалтыг тайлбарлаарай.



А. Тоглолт дуусах

Б. Байраа солих

В. Алдаа гаргах

Г. Сэлгээний тоглогч оруулах

7. Шүүгчийн заалтыг тайлбарлаарай.



А. Цаг дуусах

Б. Алдаа гаргах

В. Завсарлага авах

Г. Бөмбөгөө хураалгах

8. Шүүгчийн заалтыг тайлбарлаарай



А. 3 онооны шидэлт амжилттай болсон

Б. Бөмбөг дундаа

В. 3 секундын дүрэм зөрчсөн

Г. Алдаа гаргасан

9.  Довтолгооны тактикийг зурахдаа энэ тэмдэглэгээгээр ямар үйлдлийг тэмдэглэдэг вэ?

А. Шидэлт

Б. Залалт

В. Дамжуулалт

Г. 2 алхамт

10. Яагаад шидэлтийн төгсгөлд гарын сарвууг бугуйн үеэр нугалах хөдөлгөөн зайлшгүй шаардлагатай байдаг вэ?

А. Тоглогч эхний байрлалд шилжих зорилгоор

Б. Бөмбөгний нисэлтийн зайг нэмэгдүүлэх зорилгоор

В. Гоё техниктэй харагдах зорилгоор

Г. Шидэлтийн оновчийг нэмэгдүүлэх зорилгоор

Мэдлэг шалгах тест 1. Задгай даалгавар.

1. Холын зайн шидэлтийн зураасны гадна талаас шидэлтийг амжилттай гүйцэтгэвэл 3 оноо, энэ зураасыг гишгэх буюу дотор талаас нь шидэлтийг амжилттай гүйцэтгэвэл 2 оноо, торгуулийн шидэлтийг амжилттай гүйцэтгэх бүрд 1 оноо өгнө. Шидэлт гүйцэтгэж байх үед алдаа гаргасан бөгөөд шидэлт амжилттай болсон бол нэмэлт 1 чөлөөт шидэлт хийнэ.

А. Дундын зайнаас шидэлт гүйцэтгэх үед алдаа гаргаад шидэлт амжилтгүй болсон бол хэдэн удаа чөлөөт шидэлт гүйцэтгэх вэ? Бичнэ үү?

Б. Нэг довтолгооноор 4 оноо авах боломжийг бичнэ үү?

.....

2. Сагсан бөмбөгийн 2х1х2 хамгаалалт, 3х2 хамгаалалтын зураглал хийнэ үү?

.....

3. Сагсан бөмбөгийг дамжуулах аргуудыг нэрлэнэ үү?

.....



Биеийн тамирын хичээл дээр богино хугацаанд бичгийн тест ажиллуулахын тулд асуултуудыг том дэлгэцээр харуулах ба жижиг хэмжээний цаасыг “карт” гэж нэрлэн сурагч бүрд өгнө. Уг карт дээр сурагч өөрийн нэр болон зөв хариултын дугаарыг бичээд хураалгана. Хичээлийн дараа багш тестийн гүйцэтгэлд дүгнэлт хийж, бататгах хичээлүүд дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

3.1 Суралцахуйн үр дүнд хүрснийг харуулах баримт нотолгоо цуглуулах, түүнийг шинжлэх

Сурагчийн биеийн жин нь тэдний бие бялдрын хөгжлийн чухал үзүүлэлтийн нэг мөн. Хүүхдийн насны янз бүрийн үеүдэд биеийн жингийн үзүүлэлт нэг жилд харилцан адилгүй хэмжээгээр нэмэгдэнэ. Энэ зүй тогтолд үндэслэн сурагчдын биеийн жингийн жилийн өсөлтийн хэмжээг нас, хүйсээр тогтоосон “Монгол хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур үзүүлэлт” (Боловсролын хүрээлэн)¹¹-ийг ашиглан доорх аргачлалыг санал болгож байна. Сурагчдын биеийн жингийн хэмжээ сургуулийн өмнөх насанд эрчимтэй нэмэгдээд, сургуулийн насанд жилийн өсөлт нь аажмаар буурах боловч охид 11-12 насанд, хөвгүүд 14 наснаас биеийн жингийн эрчимтэй өсөлт ажиглагдана. Биеийн жин тухайн насны үечлэлд хэвийн хэмжээнээс илүү, дутуу байх нь зохистой хооллолт, амьдралын хэв маяг, удамшил болон бусад олон хүчин зүйлтэй холбоотой боловч хамгийн гол нь хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнөөс шалтгаална гэж үздэг. Шинэ коронавирусын хөл хорио нь сурагчийн хөдөлгөөнийг хязгаарласнаар бие бялдрын хөгжлийн чухал үзүүлэлт болох биеийн жин нэмэгдэх байдал ажиглагдсан. Сурагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, төрөл бүрийн дасгалаар тогтмол хичээллэхийг дэмжих зорилгоор тэдний биеийн жингийн үзүүлэлтийг бие бялдрын хөгжлийн оношилгоонд хэрэглэх боломжтой гэж үзлээ. Биеийн жин нь биеийн өндрийн хэмжээнээс шууд хамааралтай байдаг учраас “биеийн жин-өндрийн индекс”-ийг тодорхойлбол илүү бодит үзүүлэлт гарах боловч бид нэг цагийн хичээл дээр биеийн жин, биеийн өндөр хоёрыг хэмжиж, шинжилгээ хийх цаг хугацааны боломжгүйг тооцож зөвхөн биеийн жинг хэмжихийг зөвлөсөн.

¹¹ Эх сурвалж: “Монгол хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур үзүүлэлт, зөвлөмж”. (2018). Боловсролын хүрээлэн

Бага боловсролын түвшинд: Сурагчдын биеийн жингийн үзүүлэлтийг 4 түвшинд авч үзэж болно. 9 дүгээр сарын эхний долоо хоногийн нэг хичээл дээр хэрэгжүүлэх боломжтой.

2 дугаар анги

Зорилго:

1. Бие бялдрын хөгжлийн гол үзүүлэлт болох биеийн жинг тодорхойлох
2. Биеийн жингээ тохиромжтой байлгахад зориулсан дасгалыг гүйцэтгэх

Сурагчдын биеийн жинг хэмжихдээ:

- Гутлыг тайлуулан, цуваагаар зогсоож, ээлжлэн жинлүүр дээр гаргаж биеийн жинг хэмжээд, үзүүлэлтийг өөрт нь хэлж өгнө.
- Багш сурагч бүрийн жинг урьдчилан бэлдсэн үнэлгээний хуудас дээр тэмдэглэж авна.
- Сурагчийг жинлүүр дээр гаргаад жингийн үзүүлэлтийг 0.1 кг нарийвчлалтай тэмдэглэж авахдаа доорх үнэлгээний хуудасны тохирох нүдэнд тухайн сурагчийн биеийн жинг тэмдэглэнэ. Олон сурагчидтай ангийн биеийн жинг хэмжихдээ анги удирдсан багшийн туслалцааг аваарай.

Хүснэгт 1. 2 дугаар ангийн 7 настай сурагчдын биеийн жингийн үзүүлэлт

| № | Сурагчийн нэр | хүйс | жин багатай | хэвийн жинтэй | жин бага зэрэг илүү | жин ихтэй |
|---|---------------|------|--------------|---------------|---------------------|-----------|
| | | | 23-с доош кг | 23-24 кг | 25-26 кг | 27-дээш |
| 1 | А | эр | | 22.4 | | |
| 2 | Г | эр | 19.2 | | | |
| 3 | Л | эм | | | 24.8 | |
| 4 | У | эм | | | | 27.2 |

Сурагчдын биеийн жингийн үзүүлэлтэд шинжилгээ хийх:

- Сурагч бүрт биеийн жин нь ямар түвшинд байгааг хэлж өгөөрэй.
- Сурагчдын нас нэмэгдэх тутам биеийн жин нэмэгдэх боловч жин хэтэрхий их нэмэгдэх нь эрүүл мэндэд муу нөлөөтэй болохыг тайлбарлана.
- Биеийн жингээ хэвийн хэмжээнд байлгахын тулд тогтмол дасгал хийх хэрэгтэйг зөвлөнө.

Биеийн ерөнхий хөгжлийн дасгал:

- Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөн оролцсон 8 тоот 2-4 дасгалыг 4-5 удаа давтана.
- Эдгээр дасгалыг өдөр тутам хийж байх даалгавар өгнө.

Сурагч бүрийн биеийн жингийн үзүүлэлтэд дүгнэлт бичээд, тогтмол хийх дасгалын хамт эцэг, эхэд нь тараах материалаар хүргэвэл бүр илүү ач холбогдолтой.

3-5 дугаар анги

Зорилго:

1. Сурагч өөрийн биеийн жинг хэмжих.
2. Биеийн жингээ тохиромжтой байлгахад зориулсан шинэ дасгалыг гүйцэтгэх.

Эдгээр ангийн сурагчдын биеийн жинг 2 дугаар ангид хэрэглэсэн аргачлалын дагуу хэмжиж, доорх 2-р хүснэгтэд өгөгдсөн үзүүлэлттэй харьцуулан охид, хөвгүүдийн биеийн жингийн түвшнийг тогтооно.

Биеийн жингийн үзүүлэлтэд шинжилгээ хийх:

- 8, 9, 10 настай охид, хөвгүүдийн биеийн жин ямар хэмжээнд байвал жин багатай, хэвийн жинтэй, жин бага зарэг илүү, жин ихтэй гэж үзэхийг тайлбарлана.
- Сурагч бүр өөрийн биеийн жингийн үзүүлэлт аль түвшинд байгааг тогтооно.

Хүснэгт 2. 3-4 дүгээр ангийн сурагчдын биеийн жингийн үзүүлэлт (кг)

| Анги, нас | Жин багатай | | Хэвийн жинтэй | | Жин бага зэрэг илүү | | Жин ихтэй | |
|--------------------|-------------|---------|---------------|---------|---------------------|---------|-----------|---------|
| | охид | хөвгүүд | охид | хөвгүүд | охид | хөвгүүд | охид | хөвгүүд |
| III анги, 8 настай | 23-27 | 22-26 | 28 | 27 | 29-30 | 28-30 | 31-дээш | |
| IV анги, 9 настай | 24-29 | 26-30 | 30 | 31 | 31-32 | 32-33 | 33-36 | 34-39 |
| V анги, 10 настай | 27-32 | | 33 | 33 | 34-36 | 34-35 | 37-41 | 36-40 |

Ангийн нийт сурагчдын хэдэн хувь нь биеийн жин хэвийн, хэдэн хувь нь илүү жинтэй, хэдэн хувь нь жин бага зэрэг илүү байгааг багш тооцоолж тайлбарлана. Биеийн жингээ хэвийн түвшинд байлгахын тулд биеийн ерөнхий хөгжлийн дасгалаар тогтмол хичээллэхийг зөвлөнө.

Биеийн жингээ тохиромжтой байлгахад зориулсан биеийн ерөнхий хөгжлийн хэрэгсэлгүй дасгалыг гүйцэтгэхдээ:

3 дугаар ангийн сурагчид:

- Үндсэн зогсолтоос тулж суух, тулж хэвтэх, тулж суух, босож үсрэх 8х2 удаа
- Гараа ардаа тулж суусан байдлаас дугуй жийх 15х2 удаа
- Өвдөглөн тулж хэвтээд гар дээрээ сунаих 10х2 удаа

Эдгээр дасгалыг биеийн жин багатай ба жин ихтэй сурагчид өдөр бүр дээрх давтах тоог 2-4-өөр нэмэгдүүлэн гүйцэтгэх даалгавар өгөөрэй.

4 дүгээр ангийн сурагчид хосоороо тоглох ерөнхий хүчний тоглоом:

- Хосууд эсрэг харан сугадалцаж зогсоод бие биенийгээ нуруугаараа түлхэж 1 м зайд татсан шугамыг давуулсан нь нэг оноо авах - 3 удаа тоглоно.
- Хосууд өөдөөсөө харж хоёр гараараа бугуйнаас атгаж барьсан байдлаас нэгнийгээ чирч 1 м зайд буй шугамыг давуулсан нь нэг оноо авах - 3 удаа тоглоно.
- Хосууд өөдөөсөө харж, гараа ардаа тулан сууж хөлөө нугалж өргөсөн байдлаас нэгнийхээ хөлийг хөлөөрөө дарж газарт буулгахыг эрмэлзэх - 1 удаа газарт хөлийг буулгаж чадвал 1 оноо авна.

5 дугаар ангийн сурагчид:

- Хананд гараар тулж, налуу зогссон байдлаас гараа нугалж тэнийлгэх – 15х2 удаа
- Гараа ардаа тулж суусан байдлаас урагш явах – 18 м х 2 удаа
- Тулж хэвтсэн байдлаас зүүн мөрөө дагаж эргэн бэлтгэх байдалд орох. Дараа нь баруун мөрөө дагаж эргэх – 10х 2 удаа

✓ *Биеийн жинг хэмжиж, хэлэлцүүлэх хичээл дээр эдгээр дасгалыг гүйцэтгэхээр төлөвлөсөн учраас дасгалын тоо цөөн байгааг анхаарч, багш нэмэлт дасгалыг зохиож ашиглаарай. Бага зэрэг илүү жинтэй ба жин ихтэй сурагчдад өдөр бүр биеийн ерөнхий хөгжлийн дасгал гүйцэтгэхийг зөвлөнө.¹²*

Бие бялдрын шалгуур үзүүлэлт

Бие бялдрын хөгжлийн шалгуур нь бие бялдрын хөгжил, бие бялдрын бэлтгэлжилт гэсэн хоёр дэд хэсэгтэй. Бие бялдрын хөгжлийн шалгуурын үндсэн үзүүлэлт болох биеийн өндөр, биеийн жингийн үзүүлэлтүүдийг нас, хүйс тус бүрээр дундаж түвшин, дундаас дээгүүр буюу дунджаас доогуур, мөн дээгүүр ба доогуур гэсэн 5 түвшинтэй шалгуурыг ДЭМБ-аас практикт өргөн хэрэглэдэг. Прецентилийн аргаар Statistica Softwear 8 программаар боловсруулна. Тухайлбал, 6 настай эмэгтэй хүүхдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 112.4-118.9 см байх бөгөөд 109.75 см хүртэлх үзүүлэлттэй бол дундаж үзүүлэлт 121.9 см хүртлэх нь дунджаас дээгүүр, түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

¹² Түвшинжаргал, Р. Уртнасан, Л. Алтанцэцэг, Л. Оюундэлгэр, Ц. Мэндбаяр, Д. (2020). "Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж-Биеийн тамир II-XII.УБ:Содпресс ХХК.х.7-9.

7 настай эмэгтэй хүүхдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 117.1-123.9 см байх бөгөөд 112.6 см хүртэлх үзүүлэлттэй бол дунджаас доогуур, түүнээс доош бол доогуур өсөлтийн түвшинтэй буюу намхан хүүхэд гэж үзнэ. Харин 7 настай дундаж түвшнээс 127.9 см хүртлэх нь дундаас дээгүүр буюу түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

Хүснэгт-3. Бие бялдрын хөгжлийн сорилууд (6-10 нас)

| Хэмжих үзүүлэлт | Хэмжих нэгж |
|---------------------------------|-------------|
| Толгойн тойрог | см |
| Биеийн жин | кг, гр |
| Биеийн өндөр | см |
| Цээжний тойрог | см |
| Бүсэлхийн тойрог | см |
| Гарын атгах хүч (баруун, зүүн) | кг |

Хүснэгт-4. Бие бялдрын бэлтгэлжилтийн сорилууд (6-10 нас)

| Бие бялдрын чадавх | Гүйцэтгэх сорил | Хэмжих нэгж |
|--------------------|--|------------------|
| Хурд | 30 м гүйлт | сек |
| Уян хатан | Суугаа байдлаас бөхийлт | см |
| Хөдөлгөөний эвсэл | 10 м х3 удаа хэрж гүйх | сек |
| Хүч | Гар дээр сунайлт | давтамж буюу тоо |
| Хөлийн хүч | Байрнаас уртад харайлт | см |
| Тэсвэр | 300 м (6-7 нас) 500 м гүйлт (8-10 нас) | |

Бие бялдрын хөгжлийг дэмжих зөвлөмж:

6-10 нас нь бага боловсролын үе юм. Хүүхэд жил бүр ойролцоогоор 5-9 см өндөр болж, биеийн жин нь 2-3.5 кг-аар нэмэгддэг байна. Охид хөвгүүдийн өсөлт 10 нас хүртлээ онцын ялгаа байхгүй байна. Хүүхдийн булчин шөрмөсний хүч аажмаар нэмэгддэг ч хүүхдүүдийн жин бага туранхай байх нь бий. Хүүхдүүдийн том булчин хөгжиж, булчингийн чадал нэмэгдэх боловч гарын сарвууны булчин зэрэг жижиг булчингийн хөгжил хангалтгүй байдаг.

Хүүхдийн бие бялдрын хөгжилд амьдралын нөхцөл, биеийн тамирын дасгал хөдөлгөөн, нойр буюу унтах цаг, эцэг эх, гэр бүл багш нарийн анхаарал халамж сургуулиас зохион байгуулж буй ажил болон спортоор хичээллэж байгаа байдал нөлөөлдөг нь судалгаагаар тогтоогдсон байна.

Сургууль, багшийн түвшинд 6-10 настай хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих:

Хүүхдүүдийн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийг жилд 1-2 удаа тогтоодог ажлыг бодитойгоор хийж, ахицад дүн шинжилгээ хийхдээ биеийн тамирын багш нар, нийгмийн ажилтан, сургуулийн эмчтэй хамтран ажиллах шаардлагатай. Тоглоомын арга нь хүүхдүүд нарийн төвөгтэй хөдөлгөөнийг амархан сурч эзэмшихэд дөхөмтэй учраас бага ангийн сурагчдад хамгийн тохиромжтой хэрэглүүр бол хөдөлгөөнт тоглоом юм. Хөдөлгөөнт тоглоомын явцад хүүхдүүд ямар нөхцөлтэй тулахыг мэдэхгүйгээр тасралтгүйгээр нэг хөдөлгөөнөөс нөгөөд шилжих, тоглож буй үе тэнгийн найзуудынхаа үйлдэлтэй уялдан сэтгэх, хөдөлгөөний хүнд нарийн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх боломжтой байдаг.¹³

Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд: Сурагчдын бие бялдрын хөгжлийг тэдний биеийн жингийн өөрчлөлтөөр тодорхойлох нь зүйтэй гэж үзэж, энэ аргачлалыг доор үзүүлж байна.

¹³ Бэгз,Н.Санжаабадам,С.,Баярмаа,Б.,Лхагвасүрэн,Ц.Энхбаяр,Б.,Баярсайхан,Б.,Бүрэнжаргал,Г.,Мөнхбат,Ш.Наранцэцэг,Д. (2021). "Хүүхдийн цогц хөгжлийн оношилгоо, шалгуур үзүүлэлт 6-10 нас". УБ:Соёмбо принтинг ХХК. х.86.87.89.

6-12 дугаар анги

Зорилго:

1. Сурагч бүрийн биеийн жингийн өөрчлөлтийг илрүүлж, өмнөх ангийн үзүүлэлттэй харьцуулан шинжилгээ хийх
2. Биеийн жингээ хэвийн түвшинд хадгалахад зориулсан дасгалын ачааллыг өөртөө тохируулан, бие даан гүйцэтгэдэг болох

Сурагчдын биеийн жингээ хэмжихдээ:

- Хөвгүүд биеийн жингээ хэмжинэ.
- Охид биеийн ерөнхий хөгжлийн дасгалуудыг давтана.
- Дараа нь солигдон гүйцэтгэнэ.

Биеийн тамирын хичээлийн цаг дээр сурагчдын биеийн жингийн өөрчлөлтийг тодорхойлж үнэлэхдээ хөвгүүд биеийн жингээ хэмжиж байхад охид биеийн ерөнхий хөгжлийн дасгал гүйцэтгэхээр зохион байгуулаарай. Энэ нь ганцхан жинлүүртэй тохиолдолд хичээл зохион байгуулалтын оновчтой хэлбэр болно.

Сурагчдын биеийн жингийн өөрчлөлтийг тодорхойлохдоо:

- Сурагч бүрд ажлын хуудас тарааж өгнө.
- Сурагчид ажлын хуудас дээр бодолт хийж, өөрийн биеийн жингийн өөрчлөлтөө тодорхойлно.
- Биеийн жингийн өөрчлөлтөө өөрийн үнэлгээ хийнэ.
- Өөрийн үнэлгээг үндэслэлтэй тайлбарлахад бэлтгэнэ.

Хүснэгт 5. 6 дүгээр ангийн сурагчдын ажлын хуудас

| Сурагчийн нэр | Өнгөрсөн жилийн биеийн жин | Одоогийн биеийн жин | Өөрчлөлт | Өөрийн биеийн жинд өгөх үнэлгээ |
|-----------------|----------------------------|---------------------|----------|---|
| Д.Сугар (эр) | 36 кг | | | Биеийн жин 11 настай хөвгүүд 3 кг, охид 4 кг нэмэгдсэн бол хэвийн гэж үзнэ. Өөрийн үнэлгээг бичээрэй. |

Багш ажлын хуудсыг бэлтгэн сурагч бүрийн өнгөрсөн жилийн биеийн жингийн хэмжээг бичсэн байна. Ажлын хуудсыг тараан өгч, бодолтыг сурагчид бие даан хийнэ. Ажлын хуудас дээр тухайн насны охид, хөвгүүдийн биеийн жингийн хэвийн өсөлтийг (өөрчлөлтийг) бичсэн байх учраас энэ судалгааны баримтад үндэслэн сурагчид өөрийн биеийн жингийн өөрчлөлтөд үнэлгээ өгнө.

Биеийн жингийн үзүүлэлтийг авч үзэхдээ:

- Өөрийн биеийн жингийн үнэлгээг танилцуулах хүсэлтэй сурагч байвал сонсоно.
- Биеийн жингийн өөрчлөлтөд өгсөн өөрийн үнэлгээ нь судлаачдын боловсруулсан дундаж үзүүлэлтэд баримжаалж буй эсэхийг тодруулан ярилцана. Ингэхдээ хүснэгт 6-г ашиглан, тухайн насны сурагчдын биеийн жингийн үзүүлэлт нэг жилийн хугацаанд ямар хэмжээгээр нэмэгдэж болохыг үзүүлнэ. Үүнийг ажлын хуудас дээр бичсэн байхыг дээр тайлбарласан.
- Биеийн жин хэвийн хэмжээнээс ихээр нэмэгдэх шалтгааныг асуулт, хариултаар ярилцана. Сурагч бүр биеийн жин хэт нэмэгдэх нэг шалтгаан хэлээд урагш алхах тоглоом тоглож болно. Хамгийн олон шалтгаан нэрлэж, хол алхсан сурагч өөрийн нэрлэсэн шалтгаануудыг бусдадаа хэлж өгнө.
- Хичээлийн төгсгөлд ажлын хуудсыг хураан авч, багш дүгнэлт хийнэ.

Хүснэгт 6. 7-12 дугаар ангийн сурагчдын биеийн жингийн хэвийн өсөлтийн үзүүлэлт (кг)

| Анги | Нас | Хүйс | Биеийн жингийн жилийн өсөлтийн хэвийн үзүүлэлт |
|------|-----|---------|--|
| ҮII | 12 | охид | 5-6 кг |
| | | хөвгүүд | 3-4 кг |
| ҮIII | 13 | охид | 3-4 кг |
| | | хөвгүүд | 3-4 кг |
| IX | 14 | охид | 2-3 кг |
| | | хөвгүүд | 5-6 кг |
| X | 15 | охид | 2 кг |
| | | хөвгүүд | 4-5 кг |
| XI | 16 | охид | 2 кг |
| | | хөвгүүд | 3 кг |
| XII | 17 | охид | 1-2 кг |
| | | хөвгүүд | 3-4 кг |

Яагаад биеийн жин нэмэгдсэн, эсвэл бараг нэмэгдээгүйн шалтгааныг сурагчдаар хэлүүлээд, хариултад дүгнэлт хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй учир шалтгааныг тайлбарлаж өгнө. Биеийн жингээ тохиромжтой байлгахын тулд тохирох дасгалыг тогтмол хийхийг зөвлөнө. Үүнд: бүсэлхийн тойрог багасгах дасгал, ерөнхий жин хасах бүх биеийн булчин оролцсон дасгал гэх мэтээр сурагч бүрийн онцлогт тохируулан дасгалыг зааж өгөөрэй¹⁴.

Сурагчдын эзэмшсэн мэдлэг, хөдөлгөөний чадварын гүйцэтгэлийг оношлох аргачлал

Биеийн тамирын хичээлийн агуулга, сурагчдын зайлшгүй эзэмших мэдлэг, хөдөлгөөний чадварыг илрүүлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарах зүйлсийг тодруулан, тухайн ангийн хичээл, сургалтыг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх зорилгоор сурагчдыг оношлох үйл ажиллагааг 9 дүгээр сарын эхний долоо хоногт зохион байгуулна.

Энэхүү оношилгоо нь биеийн тамирын хичээлийг үзэж судалсны дараах сурагчдын эзэмшсэн мэдлэг, хөдөлгөөний чадварыг илрүүлэхэд чиглэсэн тул “зөв, буруу”, “сайн, муу” байна гэж үнэлж дүгнэхээс илүүтэйгээр сурагчид агуулгын хоцрогдолд орсон эсэх, хөдөлгөөний чадварын ямар түвшинд байгааг илрүүлэхэд голлон анхаарч, түвшний шалгуурыг сурагч, багш, эцэг эхэд ойлгомжтой байхаар боловсруулан аргачлалыг зөвлөсөн болно.

3 дугаар анги

Даалгавар 1. Сурагчдын бөмбөг шидэх, барьж авах чадварын гүйцэтгэлийг оношлох

- Сурагчдад жижиг бөмбөг тарааж өгөх
- Бөмбөгийг хоёр гараар дээш шидээд хоёр гараар барьж авах дасгалыг сурагчид биеэ даан давтах. Бөмбөгийг толгойноос дээш өндөрт шидээд, биедээ хүргэлгүйгээр хоёр гараар барьж авахыг багш үзүүлж, сануулна.
- 5 удаа бөмбөгөө газарт унагалгүй барьж авсан сурагчид бөмбөгөө өргөөрэй гэнэ.

Багш сурагчдын гүйцэтгэлийг ажиглан, оношилгооны хуудас дээр сурагч бүрийн гүйцэтгэлийг тэмдэглэнэ. Богино хугацаанд онолохын тулд сурагчдын нэрсийг багшийн журнал дээрх дарааллаар жагсаавал тэмдэглэл хийхэд хялбар болно.

¹⁴ Түвшинжаргал, Р. Уртнасан, Л. Алтанцэцэг, Л. Оюундэлгэр, Ц. Мэндбаяр, Д. (2020). "Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж-Биеийн тамир II-XII.УБ:Содпресс ХХК.х.10-11.

Хүснэгт 7. 2 дугаар ангийн сурагчдын бөмбөг шидэх, барих чадварын үзүүлэлт

| № | Сурагчийн нэр | Маш сайн | Сайн | Дунд | Тааруу |
|---|---------------|--|--|---|--|
| | | Бөмбөгөө дээш шидээд 5 удаа биедээ хүргэлгүй барьж авсан | Бөмбөгөө дээш шидээд 3-4 удаа биедээ хүргэлгүй барьж авсан | Бөмбөгөө дээш шидээд 4-5 удаа биедээ наан барьж авсан | Бөмбөгөө дээш шидээд 2-оос олон удаа газарт унагасан |
| 1 | Аззаяа | | + | | |
| 2 | Алтан | + | | | |
| 3 | Амар | | | | + |
| 4 | Бат | | | + | |

Хичээлийн дараа сурагчдын чадварын гүйцэтгэлд шинжилгээ хийнэ. Бөмбөгийг шидээд барьж авч чадахгүй байгаа болон биедээ наан барьж авч буй сурагчдыг анхааралдаа авна. Гэртээ энэ дасгалыг давтаж байгаад бөмбөгөө биедээ хүргэлгүй барьж авч чаддаг болсон үедээ багшдаа хэлээрэй гэсэн даалгавар өгнө.

8 дугаар анги

Даалгавар 1. Сурагчдын нам гараанаас гарч гүйх мэдлэгийг илрүүлж, үнэлэх

- Зураг дээрх даалгаврын хариултыг хэлэхийг хүснэ.
- Хөнгөн атлетикийн ямар зайн гүйлтүүд нам гараанаас гарч гүйдэг вэ? гэсэн асуултад хариулж ярилцана.

| | Сурагч Бат | Сурагч Дорж |
|---|------------|-------------|
| 1. “Гараандаа!” командаар сурагч Бат, Дорж хоёрын хэн нь зөв сууж байна вэ? | | |
| 2. “Анхаар!” командыг аль нь зөв гүйцэтгэж байна вэ? | | |
| 3. Хэн нь “Марш!” командаар гараанаас зөв гарч байна вэ? | | |

- ✓ Хөнгөн атлетикийн 100 м, 200 м, 400 м зайн гүйлтүүд нам гараанаас гардагийг дүгнэж хэлээрэй. Зураг дээрх тестийн нэгдүгээр хариулт “Дорж”, хоёрдугаар асуултад зөв хариулт байхгүй, гуравдугаар хариулт “б” гэдэг нь харагдаж байна. Нийт 6 зөв хариулт хэлэх ёстой гэдгийг тооцон, хэдийг зөв хариулснаар нь сурагчийг үнэлж болно.

Даалгавар 2. Сурагчдын нам гараанаас гарч гүйх чадварын гүйцэтгэлийг оношлох. Сурагчдыг дөрвөөр нь нэг гараанд хуваарилна.

- Нам гараанаас 30 м зайд хурдтай гүйнэ. Сурагчид ээлжлэн гарааны дохиог өгнө.

10 дугаар анги

Даалгавар 1. Волейболын бөмбөгийг доороос дамжуулах техникийн гүйцэтгэлийг оношлох

Даалгавар 2. Волейболын бөмбөгийг дээрээс дамжуулах техникийн гүйцэтгэлийг оношлох

Оношилгоонд бэлтгэж сурагчид волейболын бөмбөгийг дээрээс ба доороос дамжуулж бие халаалт хийнэ.

- Хоёр эгнээ болж, хосоороо өөд өөдөөс харан, хоорондоо охид 3.5 м, хөвгүүд 4 м зайтай зогсоно.
- 1-р эгнээ волейболын бөмбөгийг доороос, 2-р эгнээ дээрээс 10 удаа дамжуулна.
- Үүргээ сольж, 2-р эгнээ бөмбөгийг доороос, 1-р эгнээ дээрээс 10 удаа дамжуулна.
- Тасралтгүй дамжуулж чадаагүй алдсан бол дахин давтаж гүйцэтгэнэ.

Хосуудын урд талд 4 м, хажуу талд 2-3 м зайтай байхаар сурагчдыг байрлуулна. Сурагчдыг дамжуулалт гүйцэтгэх явцад нийтэд нь ажиглаж оношловол илүү үр дүнтэй болно. Энэ нь нэгдүгээрт, сурагчид шалгалт өгч байна гэсэн сэтгэгдэл төрүүлж биеэ барихаас сэргийлнэ, хоёрдугаарт бөмбөг дамжуулах дасгалаа олон удаа давтаж, чадвараа харуулах боломж олгоно. Тогтоосон зайнаас дамжуулалтыг гүйцэтгэж чадахгүй байгаа сурагч ажиглагдвал дамжуулалтын зайг ойртуулж болно.

Волейболын дамжуулалтын техник эзэмшилтийг оношлохдоо:

- Доорх шалгуурыг ашиглан сурагч бүрийн дамжуулалтын техникт үнэлгээ өгнө.
- Охид, хөвгүүд ээлжлэн дасгалыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 8. 10 дугаар ангийн сурагчдын волейболын бөмбөг дамжуулах чадварыг оношлох үнэлгээний шалгуур

| Техник | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|-------------------|---|--|--|--|
| | маш сайн | сайн | дунд | тааруу |
| Доороос дамжуулах | 1. Хөлөө зэрэгцүүлж ба аль нэг хөлийг хагас урд тавин өвдгөөр бага зэрэг нугалж зогссон. 2. Тохойг чангалан, эрхий хурууг нийлүүлэн бусад хурууг сулавтар атгасан байдлаар хоёр гарыг урагш-доош буулган бөмбөгийг тоссон. 3. Сарвууны үений дээд хэсгээр бөмбөгийг хүлээн авч тохой шулуунаар буцааж дамжуулсан 4. Бөмбөг ирж буй чиглэл рүү зөв шилжиж, оновчтой дамжуулсан. | 1. Зогсолт зөв 2. Гараа бага зэрэг доор ба дээр байрлуулсан. 3. Эрхий хуруунууд дээр бөмбөгийг хүлээн авч, тохой шулуунаар буцааж дамжуулсан. 4. Зөв шилжсэн боловч бөмбөгөө арай дээгүүр ба бага зэрэг доогуур дамжуулсан. | 1. Зогсолт зөв 2. Гараа бага зэрэг доор ба дээр байрлуулсан, эсвэл тохойг нугалсан. 3. Сарвууны үенээс нэлээд дээгүүр, эсвэл эрхий хуруун дээр бөмбөгийг хүлээн авахдаа тохойг бага зэрэг нугалж бөмбөгийг цохисон. 4. Шилжиж дамжуулсан боловч бөмбөгөө хэт дээгүүр, доогуур дамжуулсан. | 1. Хичээсэн байдалтай зогссон. 2. Гараа бага зэрэг доор ба дээр байрлуулсан, эсвэл тохойг нугалсан. 3. Сарвууны үенээс нэлээд дээгүүр, эсвэл эрхий хурууны үзүүрээр бөмбөгийг хүлээн авахдаа тохойг нугалж бөмбөгийг цохисон. 4. Бөмбөгөө өөр зүг рүү дамжуулсан. |
| Дээрээс дамжуулах | 1. Зогсолт дээрхийн адил 2. Тохойг нугалан, хуруунуудыг салган гадагш харуулж, толгойн дээд орчимд, эрхий долоовор хуруугаар гурвалжин үүсгэх маягаар байрлуулсан. 3. Хурууны өндгөөр бөмбөгийг хүлээн авч тохойн үеэр тэнийлгэн, буцааж дамжуулсан 4. Бөмбөг ирж буй чиглэл рүү зөв шилжиж, оновчтой дамжуулсан. | 1. Зогсолт зөв 2. Гараа бага зэрэг доор, дээр байрлуулсан 3. Бөмбөгний өөдөөс бага зэрэг цохих хөдөлгөөн хийж дамжуулсан. 4. Зөв шилжсэн боловч бөмбөгөө арай дээгүүр ба бага зэрэг доогуур дамжуулсан. | 1. Зогсолт зөв 2. Гараа бага зэрэг доор, дээр байрлуулсан, эсвэл хоёр гарын эрхий, долоовор хуруу хооронд их зайтай 3. Бөмбөгний өөдөөс бага цохиж дамжуулсан 4. Зөв шилжсэн боловч бөмбөгөө дээгүүр, доогуур дамжуулсан. | 1. Хичээсэн байдалтай зогссон. 2. Гараа бага зэрэг доор, дээр, эсвэл их зайтай байрлуулсан. 3. Бөмбөгний өөдөөс цохиж дамжуулсан 4. Бөмбөгөө өөр зүг рүү дамжуулсан. |

✓ *Волейболын бөмбөгийг дээрээс, доороос дамжуулах гүйцэтгэлийн түвшин тааруу буюу анхаарах шаардлагатай сурагчдыг оношилгооны хуудас дээр ялгаж тэмдэглэнэ. Бөмбөгийг дээрээс ба доороос 10 удаа алдалгүй дамжуулж буй хосууд бөмбөгөө өргөж багшид харуулахыг хэлээд хяналт тавиарай.*

- ✓ *Бөмбөгийг дээрээс ба доороос дамжуулах техник гүйцэтгэлийг дээрх шалгуураар үнэлж оношлох боловч охид 3.5 м, хөвгүүд 4 м-ээс ойрхон зайнаас дамжуулалтыг гүйцэтгэсэн бол эдгээр сурагчийн гар, хөл, нурууны хүчийг хөгжүүлэхэд анхаарах шаардлага байгааг илэрхийлнэ. Дамжуулах техникийг гүйцэтгэхдээ зогсолт, гарын байрлал, бөмбөгөнд хүрэлт, дамжуулсан бөмбөгний нисэлтийн чиглэл зэрэг үйлдлийн аль хэсэгт олон сурагч алдаа гаргаж байгааг ажиглан, 9 дүгээр ангийн хичээлийн төлөвлөлтөд тусган сайжруулаарай.*

Хүснэгт-9. Бие бялдрын бэлтгэлжилтийн сорилууд (11-17 нас)

| Бие бялдрын чадавх | Гүйцэтгэх сорил | Хэмжих нэгж |
|--------------------|---|------------------|
| Хурд | 50 м гүйлт | сек |
| Уян хатан | Суугаа байдлаас бөхийлт | см |
| Авхаалж самбаа | 10 м х3 удаа хэрж гүйх | сек |
| Хүч | Гар дээр сунилт | давтамж буюу тоо |
| Хөлийн хүч | Байрнаас уртад харайлт | см |
| Тэсвэр | 500 м (11-14 нас) 1000 м гүйлт (15-17нас) | сек |

Бие бялдрын хөгжлийн дэмжих зөвлөмж:

Онцлог 11-14 настай хүүхэд нь суурь боловсролын үе бөгөөд хүүхдийн өсөлт хөгжлийн эрчимтэй үе болно. Бие махбодын өсөлт хөгжлийн эрчимтэй үе болно. Бие махбодын өсөлт хөгжилт болон бэлгийн бойжилт хурдасч, булчингийн хөгжил сайжирна. Өмнөх настай харьцуулахад гүйлтийн хурдны хүч саарч, тогтворжино. Хүүхдийн бие бялдрын эрчимтэй өсөлтийн гурав дахь үе 11 наснаас эхэлдэг байна. Ингэхдээ охид бие бялдрын эрчимтэй өсөлт хөгжилт 11-13 насанд хөвгүүдээс түрүүлж явагддаг бөгөөд биеийн өндөр жилд 6-7 см нэмэгдэнэ, харин хөвгүүд бие бялдрын өсөлт хөгжилт 13-14 насанд эрчимжиж, биеийн өндөр жилд 6-7.6 см нэмэгдэж охидыг гүйцэж түрүүлдэг. Охид бие бялдрын эрчимтэй өсөлт хөгжил 11-13 насанд хөвгүүдээс түрүүлж явагддаг бөгөөд биеийн жин жилд 4-6 кг нэмэгдэн харин хөвгүүд бие бялдрын өсөлт хөгжил 13-14 насанд эрчимжиж, биеийн жин жилд 3-6 кг охидыг гүйцэж байна.

Ахлах ангийн буюу 15-17 насны сурагчдын бие бялдрын өсөлт эрчимтэй хөгжилт буурдаг үе. Өндрийн өсөлт, ясжилтын процесс 17-18 насанд үндсэндээ дуусна. 15-17 насны хүүхдүүдийн булчингийн хөгжил хүч чадал ихээр нэмэгдэж, нас ахих тутам охид хөвгүүдийн бучингийн хүч чадлын зөрүү 8-10 кг болно. 15-16 насанд өсвөр үеийнхний гүйлтийн хурдны хөгжил тогтворждог. Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт сурагчдын хүч, тэсвэр чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн хичээлийн хөтөлбөр болох холын зайн гүйлт, фитнес, дугуйн спорт, цана, тэшүүр болон усан спортын туслах нь зохимжтой.

Сургууль, багшийн түвшинд 11-17 настай хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих нь

11-14 нас: Хичээлийн завсарлагаанаар сурагчдыг тогтмол биеийн тамирын дасгал хийх, янз бүрийн хөдөлгөөнийг агуулсан дасгалыг хөгжмийн хэмнэлд хийлгэх. Дулааны улиралд биеийн хичээлийг зориулалтын гадаа талбайд оруулдаг байх. Дунд ангийн сурагчдад хамгийн тохиромжтой хэрэглүүр бол хөдөлгөөнт тоглоом болон янз бүрийн буухиа уралдаанууд юм.

Хүүхдийн тэсвэрийн чанар нь зүрх судасны болон амьсгалын системийн хэвийн үйл ажиллагаатай нягт холбоотой бөгөөд, нэн тэргүүнд эдгээр системийн функциональ чадварыг дасгал хөдөлгөөний ачаалалд дасгаж хөгжүүлэх шаардлагатай. Охидын хүчний болон тэсвэрт чанарыг хөгжүүлэхийн тулд зөв суниах, холын зайд гүйх дасгал хөдөлгөөнийг хийлгэх нь зүйтэй юм. Дунд ангийн сурагчдыг удаан хугацаанд ачаалаал бүхий ажил гүйцэтгэх чадвар буюу ерөнхий тэсвэрийг 500 м - 80 0м гүйлт, болон 3-6 минутын турш хөнгөн гүйлт, алхалт, хөгжмийн аянд янз бүрийн хэмнэлтэй дасгал хөдөлгөөн гүйцэтгүүлж хөгжүүлэх шаардлагатай.

Төрөл бүрийн сунгалтын дасгалаар дунд ангийн хүүхдүүдийн уян хатны чанарыг хөгжүүлэх боломжтой. Булчин, үе холбоосын уян харимхай чанарыг бие халаалт сайн хийсний дараа хийлгэвэл

тохиромжтой. Хүүхэд бүрийг спортын төрөл болох, цана, тэшүүр, сагсан бөмбөг, волейбол тоглох, усанд сэлэх тодорхой түвшний чадвартай болсон байхад анхааран ажиллах. Дунд ангийн сурагчдийн хөдөлгөөний эв дүй, авхаалж самбааг хөгжүүлэх зорилготой хөдөлгөөний нөхцөл байдал гэнэт өөрчлөгддөг дасгал хөдөлгөөн, насанд нь тохирсон буухиа уралдаан бүхий тоглоом дасгал, аэробекийн дасгал, ерөнхий тэсвэрийг хөгжүүлэх 500-800 м-ийн гүйлт зэргийг тусгах нь зүйтэй.

15-17 нас: Дулааны улиралд биеийн тамирын хичээлийг гадаа талбайд оруулах боломжоор хангах, сурагчдыг 1000-1500 м-ийн зайд гүйх боломжтой байх. 15-16 насны сурагчдад буухиа тэмцээний хэлбэрийн биеийн тамирын хичээл дээр хийлгэвэл хүүхдийн хурдны хөгжилд тустай. Биеийн тамирын хичээлээр хийх биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд хүүхдийн хөгжилд нөлөөлөх учраас аль болох олон төрлийн дасгалыг сонгож ашиглах хэрэгтэй. Ахлах ангийн сурагчдад их биеийн болон мөчдийн булчингийн хүчийг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд фитнесийн хэрэгсэлтэй хичээлийг оруулж болно. Охидын хүчний болон тэсвэрт чанарыг хөгжүүлэхийн тулд зөв суниах, холын зайд гүйх дасгал хөдөлгөөнийг хийлгэх нь зүйтэй юм.¹⁵

3.2. Нэгжийн төлөвлөлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах

Сурагчийн өөрийн үнэлгээний арга хэрэгсэл, шинжилгээ хийх аргачлал

Сурагчид үйл ажиллагаа, даалгавар, дасгалын техник гүйцэтгэлийнхээ талаар эргэцүүлэн бодох, үйл ажиллагааг төлөвлөх, сайжруулах, өөрийгөө болон бие биенээ үнэлэхэд суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сурагчийн өөрийн болон найзын (үе тэнгийн) үнэлгээг хэрэглэнэ.

Өөрийн үнэлгээний зорилго: Сурагчид өөрсдийн ур чадварыг үнэлэх, сайжруулах, хийсэн зүйлийн талаар эргэцүүлэн бодох, цааш хөгжүүлэх зорилгоо тодорхойлох бодит шаардлагыг бий болгож, идэвхтэй суралцахуйг дэмжих болно.

Өөрийн үнэлгээний арга хэрэгсэл: Өөрийн үнэлгээ нь мэдээллийн зуунд сурагч суралцах үйлээ удирдах чухал хандлага болж байгаа ба өөрийн үнэлгээг хийсний дараа биелэлт, сул тал, алдааны талаар эргэцүүлэн бодож дүгнээд, цааш өөрийгөө хөгжүүлэх зорилгоо тодорхойлно. Дараа нь зорилгоо хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж бие дааж суралцана. Сурагчийн өөрийн үнэлгээг хөгжүүлэхдээ багш нар ямар ч үед хэрэглэж болохуйц олон төрлийн арга, хэрэгслээс сурагчдын ялгаатай байдалд тохируулан сонгож хэрэглэдэг. Энэ удаад сурагчийн өөрийн үнэлгээний хэд хэдэн арга, хэрэгслийг зөвлөж байна. Аль ч арга техник, хэрэгсэл нь суралцахуйн явц болон сурагчийн ур чадварт өөрийн үнэлгээ хийхэд хэрэглэж болох юм.

Өөрийн үнэлгээ хийх алхам:

- а. Өөрийн үнэлгээг хийх
- б. Эргэцүүлэл дүгнэлт хийх (мэдэхгүй, чадахгүй байгаа, дутуу ойлгосон г.м.)
- в. Өөрөө мэдлэг, чадвараа гүйцээн суралцах төлөвлөгөө гаргах
- г. Бусад (багш, найз нөхөд)-аас дэмжлэг хүсэх

Сурагчийн мэдлэг, чадварыг оношлох, үр дүнд шинжилгээ хийх аргачлал

Зорилго: Биеийн тамирын хичээлийн цөм агуулга, сурагчдын зайлшгүй эзэмших чадвар, сурах арга барил буюу хэрэглээг Блуумын таксономын танин мэдэхүйн 6 түвшний дасгал даалгавраар илрүүлж, сурагчдын ташаа ойлголт, хоцрогдож буй агуулга, мэдлэг, чадварыг бататгах хичээл, сургалтыг төлөвлөж хэрэгжүүлэхэд оршино. Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг үнэлгээтэй уялдуулан даалгавар боловсруулж сурагчдыг оношлох нь сургалтын чанарт нөлөөлөх чухал алхам болно. Сурагчдын хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг оношлоход юуг анхаарах вэ?

1. Оношлох даалгаврыг төлөвлөнө. Зөвлөмжид тусгасан даалгавар боловсруулах бюпринтийг мөрдөнө. Хэрвээ багш өөрөө даалгавар боловсруулах тохиолдолд дараах зүйлийг анхаарна. Үүнд:

¹⁵ Бэгз,Н.Санжаабадам,С.,Баярмаа,Б.,Лхагвасүрэн,Ц.Энхбаяр,Б.,Баярсайхан,Б.,Бүрэнжаргал,Г.,Мөнхбат,Ш.Наранцэцэг,Д. (2021). "Хүүхдийн цогц хөгжлийн оношилгоо, шалгуур үзүүлэлт 11-17 нас".УБ:Соёмбо принтинг ХХК. х.93,94.

- Хичээлийн агуулга (суралцахуйн зорилт), сургалтын хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална. Ингэснээр тухайн ангийн судалсан агуулга (бүлэг сэдэв, суралцахуйн зорилт), даалгаврын танин мэдэхүйн түвшин, тэдгээр нь сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинд нийцсэн байх, төлөвлөсөн харьцаанд оношлох боломж бүрдэнэ.

2. Зөвлөмжид тусгасан сурагчийн мэдлэг, чадварыг оношлох даалгаврыг сонгож хэрэглэнэ. Багшийн сонгох даалгавар дараах шаардлагад нийцсэн байхад анхаарна. Үүнд:

- Даалгавар нь тодорхой, хэмжигдэхүйц, үйл төвтэй, цаг хугацаандаа хэрэгжихүйц, үнэлж, дүгнэж болохуйц, найдварт чанарыг хангахуйц байна.
- Даалгаврын өгөгдөл сурагчдад ойлгомжтой, хариултын ямар нэг санааг агуулаагүй байна.
- Даалгаврын хариултад илэрхий зөв эсвэл буруу хариулт оруулаагүй байна

3. Даалгаврын гүйцэтгэлээр сурагчдыг оношлох, оношилгооны үр дүнд үндэслэн тэдэнд дэмжлэг үзүүлэх, цаашдын сургалтын үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарал хандуулна. Тухайлбал,

- Сонгосон даалгавраар сурагчдыг шалгах биш тэдний агуулга эзэмшилтийг илрүүлж оношлоход чиглэнэ гэдгийг анхаарна.
- Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг рубрикийн шалгуур, түвшний дагуу шинжилж, оношилно.
- Зөвхөн багш бус сурагч өөрийгөө, бусад сурагчидтай өөрийн болон найз нөхдийн үнэлгээ хийж болохуйц хувилбарыг сонгоно.
- Багш сурагч нэг бүрийн өөрийн үнэлгээг нягталж, дараа дараагийн хичээлийн зорилт, үйл ажиллагааг төлөвлөнө.

Сурагчийн мэдлэг, чадварыг бодитой үнэлэхэд суралцахуйн зорилт, танин мэдэхүйн түвшин, агуулгын зохистой харьцааг хадгалсан үнэлгээний даалгавар маш чухал юм. Багш оношлох даалгаврын боловсруулалт хийхдээ юуны өмнө суралцахуйн зорилт, сурагчдын мэдлэгийн түвшин, гүйцэтгэлийн үр чадвар, үйлийн тогтолцоот хэлбэрийг харгалзана.¹⁶

Оношилгооны үр дүнд шинжилгээ хийх аргачлал

Оношилгоог явуулсаны дараа дараах алхмаар дүгнээд, бататгал хичээлийн агуулга, арга зүйгээ тодорхойлно. Оношилсны дараа сурагчдын ойлгоогүй, дутуу ойлгосон, алдаа зэрэг нь ялгаатай тул бататгах агуулга, арга зүй ч өөр өөр байх болно.

- а. Анхны өгөгдөл цуглуулах. (Сонгох, богино, бүтээх хариултад даалгаврын өгөгдөл)
- б. Буруу хариулт, алдааны шалтгааныг оношлох, таамаглал дэвшүүлэх
- в. Шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх.
- г. Бататгах хичээлийг төлөвлөх.
- д. Хичээлээ сайжруулах.

Багш та даалгавар боловсруулах, шинжилгээ хийх талаар багш нарт зориулсан “Даалгавар боловсруулах арга зүй”, “Даалгаварт шинжилгээ хийх арга зүй” хичээлийг судлах боломжтой. Оношилгоо нь сурагчдын хичээлийн агуулгыг эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэхэд чиглэсэн тул “зөв, буруу”, “сайн, муу” хийсэн байна гэж үнэлж дүгнэхээс илүүтэйгээр сурагчид агуулгын хоцрогдолд орсон эсэх, ямар ташаа ойлголттой байгааг илрүүлэхэд голлон анхаарна.

Агуулгыг хэсэгчлэн эзэмшсэн болон бататгах шаардлагатай сурагчид аль сэдэв агуулга болон чадвар эзэмшилт дээр анхаарах шаардлагатай байгааг тодорхойлж, шинээр төлөвлөж, зайлшгүй бататгах хичээлийн төлөвлөлтөд тусган, хичээл сургалтыг зохион байгуулна.

¹⁶ Ариунчимэг, Ш. Оюунбилэг, Ч.Энхжаргал, Х. (2020). “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж-Хөгжим I-IX”. УБ: х.15.

Сурагчдын гүйцэтгэлийн түвшинд нь үндэслэн хэрхэн дэмжих вэ?

| Дахин ажиллах шаардлагатай сурагч | Шинээр судлах шаардлагатай сурагч |
|---|---|
| Оношилгоо | |
| <ul style="list-style-type: none"> - Сурагчид өглөөний дасгалыг тогтмол хийх дадалд суралцсан байх - Сурагч тогтмол дасгал хийдэггүй, сонирхолыг нь татахгүй байж магадгүй - Хүч, хурд, уян хатан, тэсвэр, хөдөлгөөний эвслийн үзүүлэлтүүдийн зарим нь хангалтгүй үнэлэгдсэн. - Дасгалаар хичээллэх хүсэл сонирхлыг илрүүлэх. - Эрүүл мэндээ хамгаалах ба дасгалын гүйцэтгэх арга барил эзэшсэн эсэхийг илрүүлэх. - Дасгалын ачааллыг өөртөө тохируулж зөв сонгож чадаж буй эсэхийг илрүүлэх. | <ul style="list-style-type: none"> - Сурагч дасгал тогтмол хийх дадалд суралцаагүй байна. - Биеийн хүч, хурд, хөдөлгөөний эвсэл, уян хатан, тэсвэрийн үзүүлэлтүүдээ дээшлүүлэх шаардлагатай. - Биеийн тамирын хичээлийн болон дасгал хийх идэвх, оролцоог нэмэгдүүлэх, - Дасгалын гүйцэтгэлийн зөв бурууг ялган, алдааг тодорхойлох, яаж гүйцэтгэвэл зөв эсэхийг ойлгож буй байдал учир дутагдалтай. - Дасгалын техникийн үндсэн болон төгсгөл хэсгийн гүйцэтгэл хангалтгүй байна. - Дасгалыг хүч, хурд, дайлайцыг тохируулан гүйцэтгэж чадахгүй байна. |
| Сурагчид ямар дэмжлэг үзүүлж, хэрхэн туслах вэ? | |
| Сурагчид нэмэлт хугацаа өгөөд үзээрэй. Ингэхийн өмнө хийх дуртай дасгал хөдөлгөөнийг нь асуугаарай. | Хичээлийн жилийн төлөвлөлт хийхдээ заавал хийх дасгал хөдөлгөөн, техникийн гүйцэтгэлийн жагсаалт гаргаж, хэрэглэгдэхүүний нөөцийг бэлтгэх. Сурагчдын ялгаатай байдлыг үндэслэн дүнгийн гэрээ хийж, тухай бүрийн ахицыг үнэлж болно. |
| Өмнөх улиралд үзсэн дасгал, хөдөлгөөний техникийн гүйцэтгэлийг дахин хийлгэх боломжтой. | |
| Дасгалын техник гүйцэтгэлийг өөр арга хэлбэрээр зохион байгуулах | |

Сурагчидтайгаа яаж эргэх холбоо тогтоох, өөрийн үнэлгээ, суралцахуйн зорилтыг хэрхэн нэгжилж суралцахуйн үр дүнгийн шалгуур боловсруулсан, жишиг даалгаврыг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд боловсруулж, биеийн тамирын багш нар даалгавар боловсруулахад юу анхаарвал зохих зэргээр тусгаж өглөө.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. Ариунчимэг,Ш. Оюунбилэг,Ч. Энхжаргал,Х.(2020).“Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн дэмжих арга зүйн зөвлөмж.- Хөгжим”.УБ.х.5,15,
2. Бэгз,Н.Санжаабадам,С.,Баярмаа,Б.,Лхагвасүрэн,Ц.Энхбаяр,Б.,Баярсайхан,Б.,Бүрэнжаргал,Г.,Мөнхбат,Ш.Наранцэцэг,Д.(2021).”Хүүхдийн цогц хөгжлийн оношилгоо, шалгуур үзүүлэлт 11-17 нас”. УБ:Соёмбо принтинг ХХК. х.93.94.
3. Ганбат,Л. бусад, (2019). “Даалгавар боловсруулах, даалгаврын сан ашиглах арга зүйн зөвлөмж”. УБ.х.2,3.
4. Ганбат,Л. бусад. (2017). “Боловсролын үнэлгээ арга зүйн зөвлөмж”.УБ.х.8,9,10.
5. Түвшинжаргал,Р. Уртнасан, Л. Алтанцэцэг, Л. Оюундэлгэр,Ц. Мэндбаяр, Д. (2020). ”Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж-Биеийн тамир II-XII.УБ:Содпресс ХХК.х.7-9.
6. Уртнасан, Л. (2017). “Биеийн тамирын хичээлийн үнэлгээний онцлог”. Биеийн тамир, спортын онол, арга зүй сэтгүүл №54.х.25.
7. Уртнасан,Л., Бат-Отгон, Б., Уранмандах, Д., Гантулга, А., Энхтөр, М. (2018). Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III. Улаанбаатар.х.53-54
8. Уртнасан,Л. Одбаатар,Г. Тамир,Ц. Батбаяр, Д.Зоригтбаатар, Ч. (2014).”Бага боловсролын Биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж”. УБ..х.113, 146,
9. Уртнасан,Л., Бат-Отгон, Б., Уранмандах, Д., Гантулга, А., Энхтөр, М. (2018). Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III. Улаанбаатар. БМДИ. х.22-23.
10. Уртнасан, Л. ахлагчтай баг. (2019). Бага боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. УБ. БСШУСЯ.х.79,
11. Уртнасан,Л. ахлагчтай баг. (2019). Суурь боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. УБ.БСШУСЯ. х.116,
12. Уртнасан,Л., Тамир,Ц., Одбаатар,Г.,Зоригтбаатар,Ч., Номин,Б., Батбаяр, Д.(2014). Биеийн тамир IV. Багшийн ном. Улаанбаатар: Мөнхий үсэг.
13. Уртнасан,Л., Тамир,Ц.,Одбаатар,Г., Зоригтбаатар,Ч., Номин,Б., Батбаяр, Д.(2014). Биеийн тамир V. Багшийн ном. Улаанбаатар: Мөнхий үсэг.х.12-14

ЕБС-ийн Биеийн тамир хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

| | |
|----------------|---|
| Р.Түвшинжаргал | БХ, БХСС, ЭША, доктор (Ph.D) |
| У.Гэрэлт-Од | 52-р сургуулийн биеийн тамирын багш, тэргүүлэх зэрэгтэй |

Хөндлөнгийн шинжээч:

| | |
|------------|--|
| Л.Уртнасан | МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн багш, доктор (Ph.D), профессор |
|------------|--|

Техникийн редактор:

| | |
|--------------|--|
| Г. Дэлгэрмаа | Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D) |
| Ш.Сувдмаа | Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр |

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

| | |
|-----------|--------------------------------------|
| С.Мөнхмаа | Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр |
|-----------|--------------------------------------|

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 6.5 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-майл: info@eec.mn Вэб: www.eec.mn